

Улаанбаатар: ӨНӨӨДӨР

Өдөр -17
Шөнө -28

ОНИЦЛОХ ХУУДАС

ЭХ ХҮН ТӨРСӨН ҮРЭЭ
“ЗОЛИГТ ГАРГАДАГҮЙ”

V нүүрт

ЦАГ ҮЕ

ДАРХАНЧУУД ЭРЧИМ ХҮЧ, УСАН
ХАНГАМЖИЙН 2020 ОН ХҮРТЭЛХ ХӨГЖЛӨӨ
ТОДОРХОЙЛОВ

VII нүүрт

Дугаарын **60** мөр

СОНГУУЛЬ

Байшин хороолол дунд утаа гараад байна шүү

Н.ПУНЦАГБОЛД

Хотын дарга захирамж гаргаж, ямар ч тохиолдолд байшин хороолол дунд утаа гаргахыг хориглосон. Улаанбаатарын утаа гамшгийн хэмжээнд хүрч, онц байдал зарлах дээрээ тулсан учраас түүнийг хүлээн зөвшөөрч, нэн яаралтай хэдэн арга хэмжээ авсных нь нэг энэ л дээ. Дээрээ нь Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг нэг жилээр хязгаарлачихсан байгаа. Гэтэл ойрноос байшин хороолол дунд гэр барьж, утаа уугуулагчид мэр сэр үзэгдэх боллоо. Өнгөрсөн долоо хоногт Цамбагарав орчимд буюу 8, 9 дүгээр байрны дунд гэр бариад, гал түлж харагдсан. Ямар шаардлагаар байшин хороолол дунд гэр барьж, гал түлснийг бүү мэд.

Үргэлжлэл нь III нүүрт

АН-ЫНХАН ДАРГЫН СОНГУУЛЬДАА

Ж.ОТГОНМЯГМАР

Ардчилсан нам Их хурлаа хуралдуулан, намын даргаа сунгаагаар сонгохоор шийдвэрлэсэн билээ. Намын даргад нэр дэвшигчид 240 сая төгрөг намдаа хандивласнаар энэхүү сунгаанд өрсөлдөх эрхтэй болсон. Энэхүү шалгуурыг давж чадсан эрхмүүд буюу УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат, С.Эрдэнэ, Ж.Батзандан Ерөнхий сайд асан Н.Алтанхуяг, БСШУ-ны сайд асан Л.Гантөмөр, нарын таван нэр дэвшигч намын даргын сонгуульд нэр дэвшиж, өрсөлдөхөөр болсон. Нэр дэвшигчид 40 хоногийн турш үргэлжилсэн сурталчилгааны хугацаанд 21 аймаг, есөн дүүргийн АН-ын гишүүд, дэмжигчиддээ мөрийн хөтөлбөрөө танилцуулж, сурталчилгаагаа хийсэн билээ.

Улмаар сурталчилгааны хугацаа дуусч, өчигдөр Ардчилсан намын даргын сонгуулийг улс орон дааяр зохион байгууллаа. Энэ удаагийн намын даргын сонгуулийг УИХ-ын сонгуулийн санал авах үйл ажиллагаатай ижил зарчмаар явуулсан юм.

Төгсгөл II-III нүүрт



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

“...and OMEGA is the watch that went to the Moon.”

GEORGE CLOONEY'S CHOICE

Speedmaster

Sukhbaatar square, Central Tower, 2nd floor Tel: 9915-8166

ОНЦЛОХ МЭДЭЭ

Л.НИНЖЖАМЦ

МҮОНРТ-ийн Ерөнхий захирлаар томилогдлоо



эдгээр хүмүүс дээр нууцаар санал хураалт явуулж, ерөнхий захирлыг шалгаруулсан байна.

МҮОНРТ-ийн Ерөнхий захирлаар томилогдсон Лувсандашийн Нинжжамц нь хууль зүйн ухааны магистр, гадаадын орнуудад олонийтгэй харилцах чиглэлээр сурч төгссөн, Монголын хэвлэл мэдээллийн салбарт 20 жил ажилласан туршлагатай. 1996-1998 онд “Толь” сонины Ерөнхий редактор, 1998-2006, 2007-2009 онд Монголын сонинны холбооны гүйцэтгэх захирал, 2006-2007 онд МҮОНРТ-ийн Тамгын газрын дарга, 2009-2010 онд Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Хэвлэл мэдээллийн албаны дарга, 2010-2011 онд Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны даргын зөвлөх, 2011-2016 оны зургаадугаар сар хүртэл “Өглөөний сонин”-ы ерөнхий эрхлэгчээр тус тус ажиллаж байсан билээ.

МҮОНРТ-ийн Ерөнхий захирлыг шалгаруулах сонгон шалгаруулалт журмын дагуу явагдаж Үндэсний зөвлөл шийдвэрээ гаргажээ. Олон нийтийн дунд нээлттэй зарлан явуулсан сонгох шалгаруулалтад есөн нэр дэвшигч өрсөлдсөнөөс хамгийн өндөр оноогоор Лувсандашийн Нинжжамц сонгогдож, тус телевизийн Ерөнхий захирлаар томилогдсон байна. Үндэсний зөвлөлд битүүмжлэн ирүүлсэн есөн нэр дэвшигчийн материалтай ажлын хэсэг танилцаж, сонгон шалгаруулалтыг явуулжээ. Эхний шатны сонгон шалгаруулалтаас Б.Ундраа, сэтгүүлч Д.Цондовдорж, Ерөнхий захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Нинжжамц нар тунаж үлдсэн бөгөөд

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

Л.ШАГДАРСҮРЭН: ГРУППЫН МӨНГӨ ГЭДЭГ ИРГЭДИЙН АМЬЖИРГААНЫ ЭХ ҮҮСВЭР БИШ

Ж.ОТГОН

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын газрын дарга Л.Шагдарсүрэнтэй ярилцлаа.

Төр засгийн удирдлагууд солигдсонтой холбогду улсын гэх тодотголтой бүх байгууллагуудад бүтэц бүрэлдэхүүнээ шинэчлэх ажил өрнөсөн. Энэ ажил жигдэрсэн байх гэж бодож байна. Дорноговь эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн 2017 оны төсөв ямар байдалтай байна вэ. Ер нь хөдөө орон нутгийн төсөв, санхүү шаардлагатай зүйлдээ хүрэлцдэг үү?

Шинэ бүтцээр үйл ажиллагаа явуулах ажлыг гольдролд нь оруулахын тулд эхлээд бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийг хийлээ. Тэгэхдээ хоёр зарчим баримтлахыг зорьсон. Нэгдүгээрт, тогтвортой байдлыг хадгалахыг зорьсон. Учир нь манай байгууллага өөрийн гэсэн онцлогтой. Нийгмийн эмзэг бүлгийн хэнтэй харьцдаг мэргэшсэн байгууллага л даа.

Үргэлжлэл нь IV нүүрт

ХААН банк	Хуудалгаа хөгжлийн банк			
	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2450.00	2482.00	ФУНТ	3037.00
ЕВРО	2591.00	2675.00	РУБЛЬ	39.20
ИЕН	21.18	21.60	ЮАНЬ	355.00

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

Н.Учрал: Эдийн засгаа солонгоруулах гарц бол инновацийн үйл ажиллагаа юм

УИХ-ын баасан гарагийн чуулганы үдээс хойшхи хуралдаанаар УИХ-ын гишүүн Н.Учралаас “Инновацийн тухай, Үйлдвэрлэлийн дэмжих тухай хуулиудын хэрэгжилт, хуулийн хэрэгжүүлэх хүрээнд батлагдан гарсан болон гарах журмууд, тэдгээрийн хэрэгжилт, Засгийн газрын 2014 оны 374 дүгээр тогтоолын хэрэгжилт, үндэсний инновацийн тогтолцоо, инновацийн үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, цаашид хэрхэн шийдвэрлэх талаар” Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг сонслоо. Тэгвэл уг асуудлаар УИХ-ын гишүүн Н.Учрал мэдээлэл хийсэн юм. Тэрбээр “Ерөнхий сайдад инновацийн хуулийн хэрэгжилтийн талаар асуулга тавьсан. УИХ-ын дэргэд инновацийн үйл ажиллагааг дэмжих лобби бүлгийг байгуулаад ажиллаж байгаа. Эдийн засгаа солонгоруулах цорын ганц гарц бол инновацийн үйл ажиллагааг дэмжих юм. Өнгөрсөн хугацаанд төрийн байгууллагууд энэ салбарыг “Манайд хамаагүй” гэж ирээд орхигдуулсан. 2012 онд батлагдсан инновацийн хуулийг дагаж гарах журмуудаас хоёрхон журам гарсан. Өнөөдөр 28 гарааны компани байгуулагдаад ажиллаж байгаа. Гарааны компаниуд хөнгөлөлт урамшуулалыг аваагүй. Байгуулагдсан гарааны компаниуд нь лабортарийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Нэг үгээр хэлбэл, өмнөх засгийн газар нь ажлаа хийгээгүй байна. Төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоог нь сайжруулахгүй бол энэ ажил цаашаа явахгүй. Гарааны компаниудад нь боломжийг нь олгомоор байна. Эрдэмтэд маань олон патент авчихаад байдаг. Гэтэл хөрөнгө оруулагчгүй, хөрөнгө оруулагчтай холбож өгөх ажил нь бүрэн орхигдсон байна. Гадны орнуудад инновацийн агентлагууд хүртэл байгуулагдаад эхэлчихсэн байгаа. Ерөнхий сайдынх нь дэргэд инновацийн үйл ажиллагааг дэмжих зөвлөл хүртэл ажилладаг. Гэтэл манай орон энэ салбарыг орхигдуулжээ. Шинжлэх ухаан бол мэдлэгийг бүтээх үйл явц. Мэдлэгийг баялаг болгох асуудал бол инноваци. Тиймээс инновацийн үйл ажиллагаа бол ганц шинжлэх ухааны бус эдийн засгийн чухал асуудал юм” гэлээ.

Дархан чиглэлийн замыг нэгдүгээр зэрэглэлийнх болгоно гэв

Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат болон яамны холбогдох удирдлагууд, Замын цагдаагийн алба, МХЕГ-ын төлөөлүүд Улаанбаатар-Дархан чиглэлийн автозамын нөхцөл байдалтай өнгөрсөн баасан гарагт танилцлаа. Энэ чиглэлийн замд осол аваар их гардаг, замын эвдрэл ихтэй, үзэгдэх орчин хязгаарлагдмал зэрэг хамгийн эрсдэл ихтэй хэд хэдэн цэг байдаг бөгөөд тэдгээрийг хэрхэн өөрчлөн шинэчлэх шаардлагатай байгааг газар дээр нь танилцжээ. Тухайлбал Борнуурын гүүр, Тахилтын даваа, Сэтэрхийн хөтөл, зэрэг газруудад үзэгдэх орчин хязгаарлагдмал, хажуугийн хөвөө стандарт

бус учраас осол аваар ихэвчлэн гардаг “хар цэг”-т тооцогддог байна. Мөн Цайдамьн хондйи буюу 200 дахь км-г газар нутгийн онцлог буюу хөрс шорооны онцлогоос шалтгаалж ихээхэн эвдрэл үүссэн тул осол аваар ихээр гардаг байна. Улаанбаатараас Дархан чиглэлийн зам нь дөрөвдүгээр зэрэглэлийнх бөгөөд тус замаар хоногт 600 орчим тээврийн хэрэгсэл зорчих ёстой байтал хоногт 3500-3800 авто машин зорчиж байгаа албаныхан хэллээ. Тиймээс энэхүү замыг зайлшгүй дөрвөн эгнээтэй, нэгдүгээр зэрэглэлийн зам болгох шаардлагатай байгаа аж. Энэ талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат “Хөдөлгөөний эрчим ихтэй хоёр гол зам бий. Улаанбаатар-Налайх, Улаанбаатар-Дархан чиглэлийн автозамууд, УБ-Дархан чиглэлийн 230 км зам дөрөвдүгээр зэрэглэлийн зам учир ачааллаа дийлэхгүй нөхцөлд байдалд хүрээд байна. Түүнчлэн осол аваар их гарч байна. Тиймээс энэхүү замыг яаралтай өргөтгөж дөрвөн эгнээтэй, цемент бетон хучилттай нэгдүгээр зэрэглэлийнх болгон шинэчлэхэд төлөвлөж байна. Ингэснээр үндэсний үйлдвэрлэлийн цементийг ашиглаж, чанартай зам барих боломжтой” хэмээн хэллээ. Мөн хөрөнгө санхүүжилтээ гадны болон дотоодын хөрөнгө оруулалтыг босгохоос эхлээд бүх хүч, нөөц бололцоогоо нэгтгэж энэхүү замыг барьж байгуула хэмээн онцоллоо.

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

ОХУ-тай хамтарч мал сүргийг эрүүлжүүлэх II хөтөлбөрийг хэрэгжүүлнэ

Ж.ОТГОН

УИХ-ын өнгөрсөн баасан гарагийн чуулганы нэгдсэн хуралдаан 51.3 хувийн ирцтэйгээр эхэлсэн. Хуралдаанаар Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслийг хэлэлцсэн юм. Улмаар гишүүд асуулт асууж, байр сууриа илэрхийлсний дараа хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх асуудлаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэхийг дэмжсэн. Тиймээс уг асуудлыг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүллээ. Энэхүү хуулийн төслөөр дамжуулж Монгол Улсын нутаг дэвсгэрт мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжих зорилготой аж. Хэлэлцүүлгийн шатанд УИХ-ын гишүүн Д.Ганболд “Биднийг тэжээж тэтгэж ирсэн уламжлалт аж ахуйгаа зөв хөгжүүлэх ёстой. Мал амьтнаа эрүүл байлгаж байж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бодлоготой нийцүүлэх нь чухал. Хуульд тусгаж байгаа гол асуудал бол мал эмнэлэг байгуулах тухай юм. Мал эмнэлгийн салбарт эрдэмтэн, мэргэдтэй хамтарч ажиллаж байгаа юу” гэв. ХХААХУ-ийн сайд П.Сэргэлэн “Эрдэмтэд, шинжлэх ухааны сургуультай нягт хамтарч ажиллаж байгаа. “Био комбинат”-ын үйлдвэрлэлийн төхөөрөмж муудсан. Тиймээс Унгар улстай хамтарч, төсөл хэрэгжүүлэхээр болсон.

Манай “Био комбинат” малын вакцины 90 хувийг үйлдвэрлэдэг” гэдгийг талбарлаж байлаа. Мөн УИХ-ын гишүүн А.Сүхбат “Манай улс ОХУ-тай хамт хөгжсөний үр дүнд хүн малаа аварч чадсан. Гэтэл одоо малын эмчилгээний замбараагүй хэрэглээ газар авсан байна. Бид ресторана, цайны газар ороод юуны мах идэж байгаага ч мэддэггүй. Аль орны малын эм тарилга, туулга сайн бэ гэдэг нь ойлгомжгүй. Маш олон төрлийн эм тарна оруулж ирдэг. Энэ асуудлыг хэрхэн зохицуулж, анхаарч байгаа вэ. ОХУ-тай ямар хэмжээнд хамтарч ажиллах боломж бололцоо бүрдсэн бэ” гэдгийг тодруулав. ХХААХУ-ийн сайд П.Сэргэлэн “ОХУ-тай хамтарч Монгол Улсын мал сүргийг эрүүлжүүлэх II хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр болсон. ОХУ-ын төлөөлөгч 14 хоногийн дараа Монголд ирнэ. Энэ үеэр хөтөлбөрөө хэлэлцэж, батална. Хөтөлбөрт дөрвөн төрлийн чиглэлийг хамруулж байгаа” гэлээ.

Ж.Батсуурь: Олимп, дэлхийн аваргад амжилт үзүүлсэн тамирчдад жилдээ 1.4 тэрбум төгрөг зарцуулдаг

УИХ-ын чуулганы үдээс хойшхи хуралдаан Засгийн газрын цагаар үргэлжилж, УИХ-ын гишүүн Н.Учралаас Инновацийн тухай хуулийн хэрэгжилтийн асуулга, УИХ-ын гишүүн Б.Батгомөрөөс Ерөнхий сайдад хандан тавьсан асуулгын хариуг сонслоо. Үргэлжлүүлэн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Биеийн тамир спортын тухай хуулийн



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

төслийн үзэл баримтлалыг хэлэлцээд, гишүүдийн 90.9 хувийн саналаар дэмжин, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлсэн. Энэхүү төсөлтэй холбогдуулан УИХ-ын гишүүдийн зүгээс Олимп, дэлхийн аваргын тэмцээнд амжилт үзүүлсэн тамирчинд сард хэчнээн төгрөг зарцуулдаг, давхардаж олгогддог цалинг цаашид цэгцлэх эсэх асуудлаар салбарын сайдыг хариулт өгөхийг хүссэн. БСШУС-ын сайд Ж.Батсуурийн тайлбараар бол Олимп, дэлхийн аваргын тэмцээнд амжилт үзүүлэн сар бүр цалин авдаг тамирчин улсын хэмжээнд 46 байдаг. Сараар тооцвол тэдний цалинд 119.5 сая төгрөг, жилдээ 1.4 тэрбум төгрөг төсвөөс зарцуулдаг. Бусад урамшуулалтай харьцуулахад бага мөнгө. Зарим тамирчны хувьд олимп, дэлхийн аваргын тэмцээнд аль, алинд нь амжилт үзүүлсэн учраас давхардаж цалин авдаг. Дээд тал нь 7.5 сая төгрөгийн цалин авдаг. Ерөнхийлөгчийн зарлигаар олгодог цалин учраас давхардлыг өөрчлөх асуудлыг

салбарын яамнаас оруулаагүй байгаа юм байна.

Байнгын хороодын бүрэлдэхүүнийг өөрчлөх нь

УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааныг өндөрлүүлэхийн өмнө зарим Байнгын хороодын бүрэлдэхүүнийг өөрчлөх тухай асуудлыг хэлэлцэв. Гэвч УИХ-ын гишүүн Б.Батгомөр, Д.Тогтохсүрэн нар санал авалгүйгээр харьяалагдаж байсан Байнгын хорооноос гаргасан нь зохисгүй алхам гэж үзлээ. УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэн УИХ-ын Төслийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс гарган УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороонд оруулахаар, УИХ-ын гишүүн Б.Батгомөрийг УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гарган, УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд харьяалуулах болсныг боломжгүй гэж үзэв. Энэ талаар УИХ-ын гишүүн Б.Батгомөр “Нийгмийн бодлогын байнгын хорооноос гарах

Үнэхээр ч АН-ын гишүүд гадаа хүйтэн байна гэж төвөгшөөлгүй, сонгуульдаа идэвхтэй оролдож, саналаа өгч байсан юм. Санал авах ажиллагаа 12:00 цагийн байдлаар улсын хэмжээнд 35-40 хувийн ирцтэй байсан. Зөвхөн нийслэлд ч биш хөдөө, орон нутагт ч АН-ын гишүүд санал хураалтаа идэвхитэй оролцов. Зарим суманд 12:00 цагийн байдлаар ирц 60-70 хувьд хүрсэн гэдгийг мэдэж байлаа. Тухайлбал, Дорнод аймгийн хэмжээнд АН-ын даргыг сонгох сонгуулийн үйл ажиллагаа зөрчил будилаангүй, хэвийн үргэлжилж байсан бөгөөд нийт 3900 гаруй гишүүн саналаа өгөх ёстой. Үүнээс 300 гаруй хүн саналаа өгөөд байгаа ч гишүүд дараалал үүсгэсээр байна гэх мэдээллийг намын хорооноос нь өгсөн. Мэдээж АН-ын даргын сонгуульд өрсөлдөж байгаа таван нэр дэвшигч ч өөр өөрсдийн харьяа дүүрэгт очиж саналаа өгчгөөсөн. Тодруулбал, нэр дэвшигч Н.Алтанхуяг Сонгинохайрхан, Д.Эрдэнэбат Багануур, С.Эрдэнэ Баянгол, Лу.Гангомөр, гэргий А.Туулын хамт Сүхбаатар дүүргийн “Түшээ” дээд сургуулийн санал авах байранд очиж тус тус саналаа өглөө. Харин нэр дэвшигч Ж.Батзандангийн хувьд саналаа өгөөгүй байсан юм. Санал өгөх үеэрээ нэр дэвшигч



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Өөрөөр хэлбэл, АН-ын гишүүд өөрийн харьяаны аймаг, дүүрэг, сумын намын хорооны санал авах байранд очиж, саналаа өгсөн. Санал авах ажиллагаа орон даяар нэгэн зэрэг 10:00 цагт эхэлж, 22:00 цагт өндөрлөсөн юм. Сонгуулийн санал авч эхэлсэн цагаас гишүүд маш идэвхитэй сонгуульдаа оролцлоо.

2017.01.29-ний 11:00 цаг:

АН-ын дарга З.Энхболд “Түшээ” дээд сургуулийн санал авах байранд саналаа өгсөн. Түүнийг санал өгсний дараа сонгуулийн явцын талаар тодруулахад тэрбээр, “Энэ сонгууль нэг намын дотоод ажил юм шиг боловч АН Монгол Улсын төрийг сүүлийн 26 жил тасралтгүй бүрдүүлж яваа улс төрийн хүчин юм. Бид стандартын хувьд төрийн сонгуулиас дутахгүй явуулах зорилго тавьсан. Монгол Улсын бүх аймаг, сум, дүүрэгт санал хураах байр нээгдсэн. Бид анх удаа зарчмын том өөрчлөлтийг зориглон хийж байна. Аль ч нам даргаа төлөөлүүлэн сонгож, түүгээрээ бусад байгууллагаа байгуулдаг. Харин АН анх удаа дэлхийн жишигт хүрч, нийт гишүүдээрээ даргаа сонгуулж байна. Энэ нь манайд тулгамдаж байгаа

мөнгөтэй хүмүүс улс төрд орж, улс төрийн намыг өөрийн болгох, төрийн бодлогод хувийн ашиг сонирхлын зүгээс нөлөөлөх зүйлийг таслан зогсоох зорилготой. Мөн фракциудаас хамааралгүй нийт гишүүдээс дэмжлэг авсан лидертэй болох зорилгыг агуулж байгаа юм. Бид АН-ынхаа шинэчлэлийн том алхмыг хийлээ. Цаашид намын шинэчлэл олон жил үргэлжлэх байх. Үүний зэрэгцээ Ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэл, 2020 оны УИХ-ын сонгуулийн бэлтгэл гэх мэт олон ажлыг давхар амжуулж байна. Татвараа төлсөн 120 мянга орчим хүнийг хамруулж сонгууль зохион байгуулахын тулд ихээхэн хэмжээний мөнгө шаарддаг юм байна. Өнөөдөр олон хүн сайн дураараа, цалингүй ажиллаж байгаа. Орой сонгуулийн дүн гарна. Нийт таван нэр дэвшигчээ амжилт хүсье. Хэн ч сонгогдсон байсан бусад дөрвөн нэр дэвшигч дэмжиж ажиллах болно гэж амласан. Тэр амлалт хэрэгжин гэж бодож байгаа” гэв. Мөн тэрбээр “Өнөөдөр АН даргаа сонгох өдөр. Хүйтнээс төвөгшөөлгүй сонгуульдаа идэвхитэй оролдож байгаа гишүүддээ баярлалаа. Нэр дэвшигчиддээ амжилт хүсье” хэмээсэн юм.

12:00 цаг:

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУНЦЭЦЭГ 99189158**

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ 90873012**

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД 88096454**

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН 96017873**

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ 99998796**

Маркетинг, зар сурталчилгааны алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710**

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ 99042510**

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхлэсэн **Э.ЭНХЦЭЦЭГ**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: **Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот**

Харилцах утас, факс: **976-70113551**

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

УЛС ТӨР

ИДЭВХТЭЙ ОРОЛЦЛОО

Д.Эрдэнэбат “Ардчилсан намын хувь заяаны төлөө итгэл үнэмшлээрээ сонголтоо хийхийг намынхаа нийт гишүүдэд уриалж байна” хэмээсэн. Харин УИХ-ын гишүүн, нэр дэвшигч С.Эрдэнэ Баянгол дүүргийн “Энх-Орчлон” дээд сургуульд дээр байрлах санал авах байранд очиж саналаа өгсөн. Тэрбээр “Өнөөдөр бол түүхэн өдөр... Би их баяртай байна. АН-ын гишүүд маань уртаас урт дараалал үүсгэн намынхаа шинэчлэлийн төлөө саналаа өгч байна. Ийм л идэвхитэй, хүсэл тэмүүлэлтэй гишүүдийнхээ хамт АН-аа шинэчлэх болно. Үүнд эргэлзэх зүйл огт үгүй” хэмээн сэтгэгдлээ илэрхийлж байлаа.

Харин Ерөнхий сайд асан, нэр дэвшигч Н.Алтанхуяг Сонгинохайрхан дүүргийн АН-ын байранд очиж, саналаа өглөө. Тэрбээр “Өнөөдөр АН-ын даргын сунгаа болж байна. Тиймээс манай намын гишүүд намын даргаа сонгох сунгаанд идэвхитэй оролцоорой. Бүгдээрээ саналаа өгөөрэй. Та бүхний өгч байгаа санал бол зөвхөн АН-ын даргыг сонгоод зогсохгүй Монголын цаашдын хөгжил буюу хувь заяаг шийдэх түүхэн сонголт шүү” гэлээ. Дашрамд дурьдахад, Сонгинохайрхан дүүргийн Сонгуулийн хорооны дарга Ш.Даваажавын өгсөн мэдээллээр тус дүүрэгт нийт 3264 хүн санал өгөхөөс 12:00 цагийн байдлаар 600 гаруй гишүүд саналаа өгөөд байгаа гэсэн юм.

14:00 цаг:
Намын даргын сонгууль “будилаантай болно” гэсэн харьтөрүүлэх асуудал сонгууль эхлэхээс өмнө л эхэлсэн гэхэд хилсдэхгүй. Учир нь намын даргын сонгуульд намын шинэчилсэн бүртгэлд хамрагдсан гишүүд санал өгөх эрхтэй гэдгийг анх зарлаж байсан. Гэвч намынхаа нийт гишүүдийн бүртгэлийг тодорхой болгох шинэчилсэн бүртгэл явуулж албан ёсоор 176 мянга орчим гишүүн бүртгэгдсэн ч намын дарга З.Энхболд 17 мянга орчим гишүүнийг бүртгэхээс татгалзсан шийдвэр гаргасан билээ. Үүнтэй холбогдуулан АН-ын гишүүд намын удирдлагадаа шаардлага хүргүүлэх, жагсаал хийх зэргээр эсэргүүцэл илэрхийлсээр сурталчилгааны хугацааг дуусгасан юм. Тэгвэл өчигдөр болсон сонгуулийн үйл ажиллагаа элдэв зөрчил, будилаанаар дүүрэн байсан гэхэд болно. Тухайлбал, нийслэлийн Баянзүрх дүүргийн сонгуулийн штаб дээр зодоон болов. Учрыг нь торуулбал, сонгууль өгсөн иргэн гарын тэмдэглэгээ хийлгэхгүй хэмээн бухимдаж, бүртгэлийн ажилтантай зодолдож, үймээн самуун үүсгээд авсан сурагтай. Энэ мэтчилэн тус дүүрэгт л гэхэд хоёр ч удаа зодоон болоод амжсан. Мөн сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой нэр дэвшигчид хэрхэн хор найруулж байгаа талаар мэдээлэл цахим ертөнцөд цацагдсаар байсан. Тухайлбал, Баянзүрх дүүрэгт нэгэн үүрийн дарга С.Эрдэнийг дэмжүүлэх гэж гишүүддээ мөнгө тарааж буй бичлэг цацагдсан. Энэхүү бичлэгээс сонсч байхад С.Эрдэнэ хүн бүрт 10 мянган төгрөг өгсөн гэнэ. Харин энэхүү үйл ажиллагааг нь Баянзүрх дүүргийн Засаг дарга Д.Пүрэв-даваа гардан зохион байгуулсан гэлцэж байсан юм. Түүгээр ч барахгүй тус бичлэгийг УИХ-ын гишүүн асан Ц.Оюунгэрэл цацсан бөгөөд С.Эрдэнийн нэрийг татах хэрэгтэй хэмээн жиргэж байв.

16:00 цаг:
АН-ын даргыг сонгох сонгуульд 16:00 цагийн байдлаар шинэчилсэн бүртгэлд хамрагдсан гишүүдийнх нь 50 хувь буюу 60 орчим мянга нь саналаа өгчээ. Энэ нь улсын хэмжээнд 16:00 цагийн байдлаар гаргасан мэдээлэл юм. Харин орон нутагт буюу Сүхбаатар аймагт 16:00 цагийн байдлаар 41.8 хувийн ирцтэй байсан бол Баруун-Урт сумын хэмжээнд 40.13 хувьтай үргэлжилж байлаа. Тус аймгийн АН 6000 гаруй гишүүнтэй гэж үздэг. Үүнээс 3955 гишүүн шинэчилсэн бүртгэлд хамрагдсан бөгөөд эдгээр гишүүд л зөвхөн намынхаа даргыг сонгох сонгуульд саналаа өгөх боломжтой юм. Харин Баруун-Урт сумын хэмжээнд санал өгөхөөр сонгогчдын нэрсийн жагсаалтад

1271 гишүүний нэр бүртгэгджээ. Тус аймгийн сонгуулийн хорооны нарийн бичгийн дарга Б.Батбаатар “Сүхбаатар аймагт сонгуулийн үйл ажиллагаа цагтаа эхэлсэн. Намын дотоод сонгууль учир одоогоор ямар нэгэн зөрчил илрээгүй, харьцангуй тайван байна. Намын гишүүний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан гишүүд л саналаа өгөх эрхтэй учир энэхүү бүртгэлтэй холбоотой ганц нэгэн маргаан хөдөө сумдад гарах хандлага ажиглагдаж байна. Намын гишүүд маань сонгуульдаа идэвхитэй хамрагдаж байна” гэсэн юм.

Аймгуудын хувьд санал өгсөн гишүүдийн тоо харилцан адилгүй байгаа ч үндсэндээ ирц өндөр гарна гэж Сонгууль зохион байгуулах хорооноос мэдэгдсэн юм. Тухайлбал, Сэлэнгэ аймгийн хэмжээнд АН-ын нийт 6151 гишүүд байдаг. Үүнээс 16:00 цагийн байдлаар гишүүдийн 2752 нь саналаа өгч, сонгуулийн ирц 44.8 хувьтай явагдаж байлаа.

Сонгуультай холбоотой зөрчил маргааны тухайд Ардчилсан намын дарга З.Энхболдын гаргасан тушаалтай холбоотойгоор шинэчилсэн бүртгэлээс хасагдсан гишүүдийн зүгээс “Намын даргыг сонгох сонгуульд саналаа өгөх эрхийг боогдуулаа” гэсэн гомдлыг ихээхэн гаргаж байлаа. Түүнчлэн “Сонгууль өгч байгаа хүмүүс хэсгийн хорооны ажилтнуудын “Таны нэр саналын хуудсанд алга. Төв намаас хассан, бид мэдэхгүй” гэдэг үгэнд хууртах хэрэггүй юм байна шүү. Хэсгийн хороо, хаягийн бүртгэл, ер нь жижигхэн асуудлаар ч болтугай төөрүүлээд санал авахгүй байх сонирхол зарим хэсэг дээр байх шиг байна. Бүртгүүлсэн нам дээрээ очиж, хэрүүл уруул хийж, регистрийн дугаараа шүүлгэж байж өөрийнхөө шинэ хаягийг мэдэж авсан хүмүүс ч байна” гэх анхааруулга ч цацагдаж байсан юм.

18:00 цаг:
Намын даргын сонгуулийн ажиллагаанд нэр дэвшигчид бүгд л өнгөрсөн хугацаанд эвтэй байж, бие биедээ хүндэтгэлтэй хандана гэдгээ илэрхийлж байсан. Хэдийгээр намын гишүүдтэй хийх уулзалтаар өөд өдөөсөө харан мийсэж байсан ч хөшигийн ард ид өрсөлдөөн, сөргөлдөөн явагдсан нь олныхаранаас холуур өнгөрөөгүй. Мэдээж намын даргын энэ талцал хуваагдал сонгуулийн өдөр улам бүр эрчээ авч, бэхжсэн гэхэд хилсдэхгүй. Учир нь автобусаар сонгогчдыг зөөлөө, мөнгө тараалаа гэх зэргээр ёстой л нэг хөлөө жийлцэх шиг болсон. Түүнчлэн намын дарга З.Энхболдоор АН-ын даргын сонгуульд санал өгөх эрхээ хасуулсан олны танил гишүүдийн бүлэг ч энэ өдөр тодорсон. Уг бүлэгт УИХ-ын гишүүн Л.Болд, гишүүн асан М.Батчимэг, Г.Батхүү, Б.Болор, Р.Гончигдорж гээд нэлээд урт жагсаалт гарсан байсан.

Гэхдээ сонгуулийг будилаан маргаангүй зохион байгуулахын тулд бүхий л бэлтгэлийг хангаж ажилласан гэдэг нь санал хураах

байруудаас харагдаж байсан юм. Нийслэлийн хэмжээнд нийт 13 хэсэгт санал авсан. Тухайлбал, Баянзүрх дүүрэг гэхэд санал хураах хороодыг гурав хувааж, КТМС-ын номын сан, Монгол кино нэгтгэлийн хурлын заал, Жанжин клубт тус бүр санал хураасан. 18:00 цагийн үед тус дүүргийн нэгдүгээр хэсэгт 2445 гишүүн санал өгөх ёстойгоос 1000 орчим хүн санал өгсөн байсан. Санал хураах явцад нэрсийн жагсаалтад нэр нь байхгүй гэх шалтгаанаар нэлээд олон хүн буцаж байгаа гэдгийг хэсгийн ахлагч нь дуулгаж байсан. Харин хоёрдугаар хэсэгт 2400 гаруй гишүүн санал өгөх ёстойгоос ирц нь 53 хувьд хүрсэн бөгөөд бүх хэсгүүдэд санал авах ажиллагаа тайван, хэвийн явагдаж байсан юм.

22:00 цаг:
АН-ын даргын сунгаанд хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг Их хурлаараа хэлэлцүүлэн баталгаажуулна. Гэвч ялагдсан дөрөв болон тэднийг дэмжигчид олон санал авсан нэгнээ хүлээн зөвшөөрөхгүй бол яах вэ. Мөн ялагч нь 20 хувиас дээш санал аваагүй бол яах вэ, сонгууль дахих уу зэрэг асуудал үүсэх нь ойлгомжтой. Учир нь Үндэсний хэмжээний том намын дарга дээр нь бүх гишүүдийнхээ 50 хувийн саналыг авдаггүй юм гэхэд ядаж нийт гишүүдийнхээ 30 хувийн саналыг авсан хүн намын дарга болох ёстой байлтай. Энэ мэт сонгууль дагасан маргаан өрнөх нь ойлгомжтой. Юутай ч Монгол Улсын улс төрд шинэ соёлыг нэвтрүүлж байгаа гэх АН-ын даргын сонгууль улс орон даяар дуулиан шугангтай болж өндөрлөв. Сонгуулийн саналыг гараар тоолно. Тиймээс “Сумтай тав”-ын хэн нь ялалт байгуулсан бэ гэдэг нь өнөөдөр тодрох юм.

00:00 цаг:
Санал хураалт дууссаны дараа Сонгуулийн төв хороо 23:00 цагт “Blue sky”-ийн гурван давхарт сонгуулийн ирцийн талаар мэдээлэл хийлээ. Энэ үеэр Сонгуулийн төв хорооны дарга Ж.Оюунбаатар “Энэ удаагийн АН-ын даргын сонгуульд шинэчилсэн бүртгэлд хамрагдаж, сонгуульд санал өгөх эрх бүхий 120684 гишүүн саналын хуудсанд нэрс нь бичигдэж, өнөөдрийн сонгуульд оролцлоо. Нийтдээ 21 аймаг, есөн дүүрэг, 330 сум, 17 тосгонд сонгуулийн хэсэг байгуулагдан ажиллалаа. АН-ын даргын сонгууль 361 хэсгийн хороонд 10:00-22:00 цаг хүртэл үргэлжилж, өндөрлөв. Улсын дунджаар 70.75 хувийн ирцтэй, нийт 85392 хүн сонгуульд оролцож саналаа өгсөн байна. Өнөөдрийн сонгуультай холбоотой ирцийн мэдээлэл ингээд дууслаа. Яг одоо бүх хэсгийн хороод дээр санал хураалтын дүнг тоолох ажиллагаа явагдаж байна. Сумдууд дүгээ гаргаад аймаг руу, аймгийн хэсгийн хороо дүнгээ нэгтгээд онооны системд хөрвүүлээд Сонгуулийн төв хороонд ирж, нэгтгэгдэнэ. Сонгуулийн дүнг нэгтгэх ажлын хэсэг 11 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Энэ ажлыг хэсэг олон түмний нүдэн дээр ил тод байдлаар дүнг нэгтгэж харуулна. Дашрамд дурьдахад, УИХ-ын мандатаар онооны системд хөрвүүлнэ. Өөрөөр хэлбэл, нэг мандаттай аймаг 100 оноо, гурван мандаттай бол 300 оноотой гэсэн үг. Нийтдээ 8350 онооноос таван нэр дэвшигчийн авсан саналыг оноонд хөрвүүлээд хэн нь энэ сонгуульд ялсан бэ гэдгийг нь тодруулна. Сонгуулийн дүн өнөө шөнөдөө гарна” гэсэн юм.

№	Аймгуудын ирц	Хувь	11	Завхан	69.99
1	Архангай	70.14	12	Ховд	73.96
2	Булган	71.86	13	Орхон	57.60
3	Баян-Өлгий	65.16	14	Өмнөговь	72.60
4	Баянхонгор	77.96	15	Өвөрхангай	65.23
5	Говь-Алтай	70.28	16	Увс	68.98
6	Говьсүмбэр	82.87	17	Төв	76.52
7	Дархан-Уул	74.24	18	Сэлэнгэ	77.95
8	Дорноговь	67.76	19	Хэнтий	63.85
9	Дундговь	77.60	20	Сүхбаатар	67.18
10	Дорнод	68.24	21	Хөвсгөл	71.11

№	Нийслэлийн ирц	Хувь
1	Баянзүрх	72.92
2	Хан-Уул	66.69
3	Сонгинохайрхан	70.29
4	Чингэлтэй	75.16
5	Баянгол	72.90
6	Сүхбаатар	82.85
7	Багануур	80.03
8	Багахангай	91.62
9	Налайх	69.68

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



Дугаарын 60 мөр
Байшин хороолол
дунд утаа гараад
байна шүү

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Ямар ч байсан Хотын даргын захирамжийг биелүүлэггүй, байшин хороолол дунд гал түлж, утаа гаргаж байсан нь л үнэн. Харин хоёр, гурав хоногоос өнөөх гэрээ буулгачихсан харагдана билээ. Ямар нэг зайлшгүй хэрэг гарсан байх л даа. Гэвч “Ямар ч тохиолдолд байшин хороолол дунд утаа гаргахыг хориглоно” гэдэг шийдвэр яах болж байна. Одоо хэдхэн хоноод хоёрдугаар сар гарлаа. Цагаан сар ч дөхлөө. Энэ өдрүүдэд ууц, өвчүү чанаж үйлчлэх хүмүүс хаа сайгүй гарч ирдэг. Тэгээд байшин хороолол дунд гэр бариад, гал түлээд, утаа уугуулаад л суучихна даа. Бүр олон жил нэг газар гэр барьж, тэр хавийнхаа орон сууцны айлуудын ууц, өвчүү чанаж өгдөг хүмүүс ч бий. Тэр нөхдүүд эвтэйхэн газар олоод гэрээ бариад, ууцаа чанахыг үгүйсгэх газар байхгүй. Хотын даргын захирамж гарсан болохоор тэгэхгүй байх гэж саналгүй. Манайхан тоохгүй л гэрээ бариад, галаа түлээд, ууцаа чанана. Хүмүүс л утасдаж мэдэгдээд, шаардаад, хэлээд байхгүй бол манай төрийн байгууллагынхан, харуцах ёстой нохдүүд нь анзаарах ч үгүй. Зарим нь харсан ч, мэдсэн ч тоохгүй. Эсвэл очоод хэдэн төгрөг аваад дуугүй л өнгөрнө. Зарим нэг нь “Танч хоног ууцаа чанаж байгаад больчихоорой” гэж хэлчихээд хаячихаад яваад өгнө. Иймэрхүү сэтгэлгүй хүмүүс төрийн байгууллагаар дүүрчихсэн байгаа шүү дээ, үнэндээ. Тийм болохоор Хотын даргын захирамж биелэхгүй байх вий дээ гэхээс санаа зовоод байна. Зарим хүмүүс нь “Тэртэй тэргүй энэ их утаатай байхад хэдэн хүн гэр бариад, гал түлээд, ууц чаналаа гээд яав л гэж” хэмээн гөжинө. Тэгээд гэрээ барина, галаа түлнэ, ууцаа чанана. Хоёрдугаар сарын 10 хавьцаанаас эхлээд байшин хорооллын дунд гэр барьж, утаа гаргахыг ёстой нэг үзүүлэх байна. Тийм болохоор эрхэм дарга нар минь гаргасан захирамжийнхаа биелэлтэд анхаарч ажиллаарай. Индэрийн ард зогсоод захирамж уншиж, танилцуулах амархан. Харин тэр захирамжийнхаа биелэлтийг хангана гэдэг чинь Дагваа аваргын хэлдгээр алаан байхгүй юу. Тэр дундаа цагаан сарын өмнө, ууц, өвчүү чанах бизнес цэцэглэх үеэр жинхэнэ утгаараа “дайн” болно. Ийм үед л Хотын дарга захирамжийнхаа хэрэгжилтийг хангуулж чадвал бусад үед бол яах вэ. Тэртэй тэргүй цагаан сараас бусад үед хүмүүс байшин хорооллын дунд гэр бариад, гал түлээд, утаа гаргаад байхгүй. Ер нь бол гэр барьж, ууц чанахад тодорхой зөвшөөрөл авдаг байсан, өмнөх жилүүдэд. Өнөө жил бол тийм зөвшөөрөл өгөхгүй байх л даа. Гэхдээ манайханд зөвшөөрөл энэ төр сонин биш. Гэр нь л байхад хангалттай. Шууд бариад, ганц хоёр өдөр ууцаа чанаад, хүмүүс ирээд хөөж туувал буулгачихна, тэгээд л гүйцээ. Ийм зүйлс хоёрдугаар сард болох нигуур их тул холбогдох хүмүүс нь сонор сэрэмжээ жаахан дээшлүүлээрэй гэж зөвлөх гээд байна. Эхнээсээ гэр бариад, утаа гаргаад, маргаан нөгөөдрөөс нь буулгаад байна, цаана чинь.

ОНЦЛОХ ХУУДАС

Сенсаацийн эргэн тойронг

ЭХ ХҮН ТӨРСӨН ҮРЭЭ “ЗОЛИГТ ГАРГАДАГГҮЙ”

Энэ сарын 23-24-нд шилжих шөнө Сүхбаатар дүүргийн долдугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах хогийн цэгээс дөнгөж төрсөн нярай хүүхдийн хөлдсөн цогцос олдож, олны сэтгэлийг сөрдхийлгээ. Харамсалтай нь, эрдэнэт хүний биенийг олж төрсөн бяцхан үрээ хог адил хаяад явах харгис сэтгэлтэй “алуурчид” олшрох болж. Тиймээс “Монголын мэдээ” сонин энэ удаагийн “Онцлох хуудас”-аараа энэ төрлийн гэмт хэргийг онцолж байна. Өмнө нь төрсөн эх нь ой долоон сартай хүүхдээ хүйтэн оронд хаяж явсны улмаас үхэлд хүргэсэн жигшүүрт хэрэг гарч байсан. Тэгвэл энэ удаа төрсөн үрээ хогийн цэгт хаяад явжээ.

ӨНГӨРСӨН ОНД НАЙМАН ХҮҮХДИЙГ ЭЦЭГ, ЭХ НЬ ХАЯЖЭЭ

2017.01.28: Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуульд хүүхдээ хаях, төөрүүлэх нь гэмт хэрэгт тооцогдоно. Энэ төрлийн гэмт хэрэг хэдийгээр буурч байгаа ч эцэг эхчүүдэд хариуцлага хүлээлгэхийн сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх шаардлагатай байна. Ингэснээр болзошгүй эрсдлээс сэргийлэх юм. 2015 онд хүүхдээ хаяж төөрүүлэх гэмт хэрэг 15 бүртгэгджээ. Харин өнгөрсөн онд найман хүүхдийг эцэг, эх нь хаяж төөрүүлсэн байх юм. Тэдэнд хуулийн хариуцлага хүлээлгэж Эрүүгийн хуулийн 117-р зүйлд зааснаар шийтгэсэн байна. Тодруулбал Эрүүгийн хуулийн 117 дугаар зүйл. Хүүхэд хаях, төөрүүлэх 117.1.Төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдээ хаясан, төөрүүлсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс гурван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. 117.2.Энэ хэргийн улмаас хүүхдийн амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж заасан байдаг. Бага насны хүүхдийг хаяж төөрүүлэх нь хүүхдийн амь насанд шууд заналхийлж байгаа хэрэг. Тиймээс хуулийн хариуцлага хүлээлгэх нь зүйн хэрэг. Гэхдээ асран хамгаалагчийг нь шоронд хорилгоо гээд хүүхдийн амьдралд өөрчлөлт гарахгүй. Тиймээс албадан сургалтад хамруулж хүүхдээ хайрлахад сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх хэрэгтэй. Амьдралын хар бараан дундаас хүүхэд гэдэг гэрэл гэгээг олж харахад сэтгэлзүй туслана гэдгийг мэргэжлийнхэн сануулж байна. Статистик судалгаагаанаас харахад Улаанбаатар хотод хүүхдээ хаяж төөрүүлэх нь харьцангуй их байдаг. 2016 онд найман хүүхдээ хаяж төөрүүлсний долоо нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн. Нэг нь Булган аймагт үйлдэгджээ. Өөрөөр хэлбэл, Улаанбаатар хот дахь амьдралын төвшин орон нутгаас хүнд байдагтай шууд холбоотой байдаг байна.

ОЙ ДӨРВӨН САРТАЙ ОХИНОО ЗОЧИД БУУДАЛЦ ХАЯЖ ЯВЖЭЭ

2016.03.21: Зочид буудлын өрөөнд хүүхдээ орхиж явсан хэрэг гарчээ. Тодруулбал “Сонгинохайрхан дүүргийн 13 дугаар хороонд байрлах “.....” зочид буудлын өрөөнд хүүхэд орхисон байна” гэх мэдээлэл энэ сарын 19-ний өдөр цагдаагийн байгууллагад иржээ. Дуудлагын дагуу шалгахад тус зочид буудлын ... тоот өрөөнд ой дөрвөн сартай Х охиныг орхиж явсан байжээ. Охиныг төрсөн ээж нь болох Чингэлтэй дүүргийн 18 дугаар хороонд оршин суух хаягтай 33 настай, О гэгч эмэгтэй орхиж явсныг цагдаагийн алба хаагчид илрүүлсэн байна. Х охиныг Сонгинохайрхан дүүргийн хүүхдийн эмнэлэгт хэвтүүлэн эмчлүүлж байгаа аж. Хэргийг Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн гурвдугаар хэлтэст шалгаж эхэлжээ.

ТӨРСӨН ХҮҮХДЭЭ ХАЯЖ ЯВСАН ЭХЭД 5 ЖИЛИЙН ЯЛ ОНООЛОО

2016.05.12: Нийслэлийн

Сүхбаатар дүүргийн аравдугаар байрны оронд ой долоон сартай охиноо орхисон хэрэг өнгөрсөн нэгдүгээр сард гарсан. Тэгвэл Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд Сүхбаатар дүүргийн Прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 117 дугаар зүйлийн 117.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн Б.Долгорсүрэн, Б.Чанцалдулам нарт холбогдох эрүүгийн хэргийг энэ сарын 2-ны өдрийн шүүх хуралдаанаар хянан хэлэлцлээ. Улмаар Б.Долгорсүрэнг төрүүлсэн хүүхдээ хаясны улмаас хүүхдийн амь нас хохирсон гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд, шүүгдэгч Б.Чанцалдуламыг Б.Долгорсүрэнг төрүүлсэн хүүхдээ хаясан гэмт хэрэг үйлдэхэд хамтран оролцсоны улмаас хүүхдийн амь нас хохирсон гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцож, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 117 дугаар зүйлийн 117.2 дахь хэсэгт зааснаар Б.Долгорсүрэнг таван жилийн хорих ялыг жирийн дэглэмтэй эмэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлж, Б.Чанцалдуламыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасныг журамлан мөн хуулийн тусгай гурван жилийн хугацаагаар хорих ялыг жирийн дэглэмтэй эмэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлэхээр шийдвэрлэсэн байна.



ТӨРСӨН ХҮҮХДЭЭ ХӨНӨӨСӨН ГЭХ ЭМЭГТЭЙГ ЭРЭН СУРВАЛЖИЛЖ БАЙНА

2017.01.24 : Төрсөн хүүхдээ хөнөөсөн гэх 24 настай эмэгтэйг цагдаагийн байгууллагаас эрэн сурвалжилж байна. Тодруулбал, Болормаа овогтой Лхагвацэрэн нь өөрийн нэг ой 20 хоногтой охиноо хөнөөсөн гэх хэрэгт сэжиглэгдэн эрэн сурвалжлагдаж байгаа аж. Албаны эх сурвалжийн мэдээлснээр Б.Лхагвацэрэнг охиноосоо гадна өөр нэгэн хүн амины хэрэгт холбогдуулан шалгаж байгаа гэнэ. Энэ талаар эх сурвалж “2015.07.21-ний өдөр Чингэлтэй дүүргийн 9 дүгээр байрны гаднаас нэр хаяг тодорхойгүй 50-55 насны зүүн нүд хөхөрсөн эрэгтэй хүн ГССҮТ-д хүргэгдэн ирж нас барсан хэрэг гарсан. Тэр хэрэгт Б.Лхагвацэрэнг сэжиглэж байгаа” хэмээн мэдээлсэн юм. Учир битүүлгээр амиа алдсан эрэгтэйн болон төрсөн охиноо хөнөөсөн хэрэгт сэжиглэгдэн эрэн сурвалжлагдаж буй энэ эмэгтэйн талаархи мэдээллийг 70120132 дугаарт хүлээн авч байна.

ТӨРСӨН ҮРЭЭ ЗҮҮГЭЭР ШИВЖ ХӨНӨӨХИЙГ ЗАВДЖЭЭ

2017.01.21: Төрөөд 10 хонож байсан хүүгийнхээ амь насанд халдахыг завдсан аймшигтай хэрэг гарсан билээ. Хэрэг Баянхонгор аймагт үйлдэгдсэн бөгөөд эмэгтэйг иргэдийн мэдээллийн мөрөөр шуурхай илрүүлэн, саатуулсан. Улмаар аймгийн эмч нар хүүхдэд яаралтай тусламж үзүүлж амь насыг нь аварсан. Тухайн нярай төрөхдөө дутуу төрсөн бөгөөд эмч нар эмчилж биений байдал нь дээрдэж, эмнэлгээс гаргасан байна. Гэвч эмнэлгээс гараад удаагүй байхад нь төрсөн эх нь хүүхдийг амьд үлдэхгүй байх гэх шалтгаанаар санаатай алахыг завджээ. Эх сурвалжийн хэлж буйгаар хүүгийн эх 1991 онд төрсөн, Баянхонгор аймгийн харьяат иргэн Ц гэгч аж. Тэрбээр өөрийн төрүүлсэн 1 кг 800 г жинтэй эрэгтэй хүүхдийг зүүгээр бүх бие рүү нь, тухайлбал цээжин тус газарт нь олон удаа шивсний улмаас хүнд гэмтэл учруулсан тогтоогдсон байна. Одоогийн байдлаар хүнд гэмтэлтэй нярай ЭХЭМҮТ-ийн сэхээний тасагт хэвтэн эмчлүүлж байгаа аж. Нярайг ирсэн даруйд гурван удаа хагалгаанд оруулсан бөгөөд цээжин тус газраас нь зургаан ширхэг зүү эхний хагалгаагаар гарган авчээ. Хэргийг тус аймгийн цагдаагийн хэлтэс Эрүү үүсгэн шалгаж байгаа юм байна. Болсон хэрэг явдлын талаар хүүгийн эх Ц нь “Амьд үлдэхгүй байх гэж бодоод ийм хэрэг үйлдсэн. 10 гаруй зүү шивсэн” хэмээн цагдаа нарт мэдүүлж өгсөн байна.

НЯРАЙН ХӨЛДСӨН ЦОГЦОС ОЛДЛОО

2017.01.27: Сүүлийн хоёр жилд нярай хүүхдээ хаях, амийг нь санаатайгаар хохироосон хэрэг цөөнгүй гарч байна. Энэ сарын 24-ний өглөө Сүхбаатар дүүргийн нэгдүгээр хэлтэст ирсэн иргэний дуудлагын дагуу очиход Сүхбаатар дүүргийн наймдугаар хорооны нутаг дэвсгэр МУБИС-ийн оюутны тавдугаар байрны ойролцоох хогийн цэгээс хөлдсөн нярай хүүхдийн цогцос олджээ. Цогцос 3.8 кг жинтэй эрэгтэй хүүхэд байжээ. Одоогоор цогцосыг задлан шинжилгээн өгсөн байна. Харин хүүхдээ төрүүлээд хаясан байж болзошгүй эхийг эрэн сурвалжилж байгаа аж. Тиймээс жирэмсэн байсан, жирэмсний хугацаандаа төрөөд учир битүүлгээр хүүхэд нь алга болсон, эхийн талаар мэдээллийг Сүхбаатар дүүргийн цагдаагийн нэгдүгээр хэлтэст болон 94374924 дугаарын утсанд мэдэгдэнэ үү.

Сэтгүүлчийн өнцөг

ХҮҮХЭД ХОГ БИШ

Б.СУМЬЯА

Хорвоогийн хамгийн аугаа Ххайр, сайхан сэтгэлийн бэлгэдэл нь эх хүн. Угтаа эх хүн болж энгэртээ эрдэнэ тэвэрнэ гэдэг атга будаа дээш цацахад зүүний үзүүрт тогтох ганц ширхэг будаатай адил хүсээд заяахгүй хувь тавилан. Гэтэл биеэ хувааж, зовлогоо зулгаан байж төрүүлсэн бяцхан үрээ хог мэт үзэн хаяж, төөрүүлсэн тохиолдол сүүлийн үед нэмэгдэх болжээ. Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд л гэхэд хүүхдээ төрөнгүүт нь хаясан тохиолдол 2015 онд 10, 2016 онд ес бүртгэгдсэн байх юм. Саххан л гэхэд төрүүлсэн үрээ хогийн цэгт хаяж явсан хэрэг гарсан. Энэ сарын 23-24-нд шилжих шөнө Сүхбаатар дүүргийн долдугаар хороо, МУБИС-ийн оюутны байртай залгаа хогийн цэгээс 3800 кг жинтэй нярай хүүхдийн

хөлдсөн цогцос олдсон нь олны сэтгэлийг сөрдхийлгэсэн юм. Эрэгтэй хүүхдийн цогцос эхсээсээ салаагүй байсныг эх сурвалжууд онцолж байсан. Энэ хэргийг эдүгээ тус дүүргийн цагдаагийн нэгдүгээр хэлтсийнхэн шалгаж, төрүүлсэн эхийг нь эрэн сурвалжилж байгаа юм. Өмнө нь үүнтэй төстэй хэрэг 2006 онд гарч байжээ. Тухайн үед Гандангийн орчмоос эхэстэй нь хаясан нярай хүүхдийн цогцос олдож байсан бөгөөд эл хэрэгт төрүүлсэн эх нь холбоотой болохыг албаныхан тогтоож байсан гэдэг. Түүнчлэн, өнгөрөгч онд ой долоон сартай охиноо хүйтэн оронд унтуулж орхисон хэрэг мөн гарч, цагдаагийн байгууллага шуурхай илрүүлж байсныг хүмүүс одоо ч санаж буй биз.

Тэр үед төрсөн эх нь “Хүүхдээ өсгөх боломжгүй” гэх шалтгаанаар хаяж явснаа мэдүүлсэн байдаг.

...Хүүхэд хог биш. Хорвоод ирэхдээ л идэх хоол, өмсөх хувцастайгаа ирдэг бяцхан сахиусан тэнгэрүүдийг өрхийн амьжиргааны төвшин доогуур, өсгөж чадахгүй гэх шалтгаан, эсвэл зүгээр л амин хувиа бодсон арчаагүй сэтгэлээр хорвоогоос “хөөх” эрх хэнд ч байхгүй. Тэр ч бүү хэл, төрүүлсэн эхэд нь ч байх ёсгүй...

Эрүүл мэндийн байгууллагын мэдээллээр хяналтгүй төрөлт ч энэ төрлийн гэмт хэрэгтэй холбоотой байдаг ажээ. Нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн 80-85 хувь нь л оршин суугаа хороо, дүүрэгтээ жирэмсний хяналтад орсон байдаг бол үлдсэн хувь нь хяналтад оролгүй явсаар эмнэлгийн бус газарт төрдөг байх юм. Жирэмсний хяналтад ордоггүй ээжүүдийн дийлэнх нь оюутнууд, орон нутгийн эмзэг давхаргынхан, орон гэргүй тэнэмэл эхчүүд байдаг ажээ. Тэдний ихэнх нь хаягийн зөрчилтэй, иргэний үнэмлэхгүй байдаг төдийгүй хаана хяналтад орохоо мэдэхгүй явсаар төрдөг байх юм.

Хөдөө, орон нутгийн оюутнууд ч мөн хаана хяналтад орохоо мэдэхгүй явсаар төрөхийн өмнөхөн л эмчид очиж, эцэстээ

хүүхдээ төрүүлээд хаяж явах тохиолдол байдаг ажээ. Хүүхдээ хаяж, орхино гэдэг гэмт хэрэг. Хэн ч энэ хэргийн хариуцлагаас мултрахгүй. Эрүүгийн хуулийн 117 дугаар зүйлд “Төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдээ хаясан, төрүүлсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс гурван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ”, мөн “Энэ хэргийн улмаас хүүхдийн амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж тусгасан байдаг.

Тиймээс хуулийн хариуцлагаас зугтах, эрх хэнд ч байхгүй. Угтаа нэг хэсэг нь хүсээгүй жирэмсэлж, хүүхдээ хаяж голж байхад нөгөө талд нь хүүхдийн цангинах инээд, уйлах дууг сонсч, бяцхан хөл гарыг нь үнсэн баярлаж, бүүвэйн дуу аялах хувь дутсан эмэгтэйчүүд ямар их байдаг гэж санана. Үнэхээр хүүхдээ өсгөх боломжгүй юм бол хаяж, амийг нь бүрэлгэн бүх насаараа “алуурчин” нэр зүүж явахын оронд хүүхэд хүссэн олон мянган гэр бүлд үрчлүүлж ягаад болохгүй гэж. Эсвэл асрамжийн газарт өгөөд өсгөж болно. Хүүхэд хог биш. Хорвоод ирэхдээ л идэх хоол, өмсөх хувцастайгаа ирдэг бяцхан сахиусан тэнгэрүүдийг өрхийн амьжиргааны төвшин доогуур, өсгөж чадахгүй гэх шалтгаан, эсвэл зүгээр л амин хувиа бодсон арчаагүй сэтгэлээр хорвоогоос “хөөх” эрх хэнд ч байхгүй. Тэр ч бүү хэл, төрүүлсэн эхэд нь ч байх ёсгүй. Тийм зэрэмдэг сэтгэлтэн Монголын нийгэмд цөөн байгаасай.

ДЭЛХИЙ

Д.ТРАМП ДОЛОО ХОНОГТ 14 ЗАРЛИГТ ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА

Б.ДАВААХҮҮ

АНУ-ын 45 дахь Ерөнхийлөгч Доналд Трамп тангараг өргөсөн өдрөөсөө эхлэн ажилдаа орж, хэд хэдэн зарлигт гарын үсэг зуржээ. Тодруулбал, ердөө долоо хоногийн дотор 14 зарлигт гарын үсэг зурж, Барак Обамагийн амжилтыг давсан юм. Өмнөх Ерөнхийлөгч Барак Обама 2012 онд тангараг өргөснийхөө дараа долоо хоногт 12 зарлигт гарын үсэг зурж байв. Д.Трампын үзэглэсэн зарлигаас онцолж дурьдвал, “Obamacare” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэс болсон “Хүртэмжтэй эрүүл мэндийн даатгал”-ын тухай хуулийн дагуу төрийн байгууллагуудад тавигдаж буй шаардлагуудыг зөөлрүүлэх тухай зарлигт гарын үсэг зурсан бол Цагаан ордонд ажиллах эхний өдрөө АНУ Номхон далай дамнасан түншлэлийн гэрээгээс гарах зарлигийг мөн үзэглэв. Түүнчлэн, сонгуулийн кампанит ажлын үеэр Мексик-АНУ-ын хил дагуу хана босгоно гэх амлалтаа биелүүлж, энэ сарын 25-ны өдөр хана босгох зарлигт Д.Трамп гарын үсэг зурлаа. Сонгуулийн сурталчилгаа үргэлжилж байсан эл өдрүүдэд Трампын энэхүү амлалт зарим хүмүүст наргиа мэт сонсогдож байсан нь гарцаагүй. Гэвч, тоглоом шоглоом биш байсныг батлан дээрх шийдвэрийг гаргасан нь олон улсын анхаарлыг татсан юм. Тэрбээр АНУ-ын өмнөд хилийн

аюулгүй байдлыг хамгаалах үүднээс хана босгох шийдвэрийг гаргажээ. Гэхдээ хамгийн сонирхолтой нь эл хананы бүтээн байгуулалтад зарцуулагдах хөрөнгийг Мексикээс гаргуулах тухай яриа юм. Бүтээн байгуулалтын ажил ойрын үед эхлэх бөгөөд түүний зардлыг АНУ-ын төсвөөс гаргаж, явцын дунд Мексикээс импортын татвар байдлаар нөхөн авах аж. Тэгвэл Д.Трампын шийдвэрт Мексикийн Ерөнхийлөгч Ч мөн харигт нь барьсан байна. Мексикийн Ерөнхийлөгч Энрике Пенья Ньето хана босгох мөнгийг төлөхгүй гэдгээ илэрхийлсний зэрэгцээ айлчлалаа цуцлаад байгаа юм. Мөн АНУ-ын шинэ Ерөнхийлөгчийн анхаарал татсан шийдвэрийн нэг нь мусульман шашинтнуудыг хориглох зарлиг юм. Тэрбээр аюулгүй байдлын хүрээнд террорист халдлага үйлдэж болзошгүй нийт долоон улсаас тус улсыг зорин ирэх мусульман шашинтнуудыг хил нэвтрүүлэхгүй байх тухай зарлигт гарын үсэг зурсан байдаг. Тэдгээр улсад Сири, Иран, Ирак, Ливи, Йемен, Судан, Сомали багтжээ.

Нисэх буудлуудад 27 хүн саатуулагджээ

Тэгвэл зарлигт гарын үсэг зурсны дараагаас эхлээд АНУ-д эмх замбараагүй байдал үүсч эхэлсэн байна. Нью-Йорк хотын



Жон Кеннедигийн нисэх онгоцны буудлаас эхлээд орон даяархи нисэх буудлуудад албаныхан олон тооны ирак хүмүүсийг баривчлсан гэх мэдээлэл байгаа юм. Ерөнхийлөгчийн зарлигт Сирийн дүрвэгсдийг тодорхойгүй хугацаагаар хүлээн авахыг хориглож, дээрх долоон орны иргэдийг АНУ-д ирэхийг 120 хоног хориглох гэх мэт заалт тусгагдсан байдаг. Тэгвэл Д.Трамп зарлигт гарын үсэг зурсны дараа Жон Кеннедигийн нисэх онгоцны буудалд 12 хүн саатуулагджээ. Тэдний дунд АНУ-ын цэргийн орчуулагч ажилтай нэг ирак хүн өнгөрөгч бямба гарагт суллагдаж, АНУ руу нэвтэрчээ. ABC телевизийн мэдээлж буйгаар нийтдээ дөрвөн нисэх буудалд 27 хүн саатуулагдсан бол АНУ-ын их, дээд сургуульд суралцаж оюутнууд ч буцаж чадалгүй гацжээ. Гэтэл энэ мэт эмх замбараагүй байдал

үргэлжилж байхад Д.Трамп “Цагаачлалыг хязгаарлах бодлого үнэхээр сайн хэрэгжиж байна. Нисэх онгоцны буудлаас үүнийг харж болно” гэж жиргэсэн байлаа. Ямартай ч, дээрх долоон орны иргэд АНУ руу нэвтрэх тохиолдолд ногоон карттай эсэхээс үл хамааран Консулын газар гэх мэт холбогдох байгууллагад хандан тус улс руу нэвтрэх шаардлагатай эсэхээ баталгаажуулсныхаа дараа л хил давах боломжтой болж буй гэнэ.

Канад дүрвэгсдийг урьж, Иран АНУ-ын иргэдэд хориг тавив

Доналд Трамп террорист халдлага зохион байгуулж болзошгүй долоон орны иргэдийг хил нэвтрэхийг хориглох зарлигт гарын үсэг зурсны дараа эсрэгээр

Канадын Ерөнхий сайд Жастин Трүде “Канад дүрвэгсдийг хүлээн авна” хэмээн твиттер хуудастаа жиргэжээ. Тэрбээр “Дарамт, хавчлага, терроризм, дайн самуунаас зугтаж ирсэн хэнийг ч хэн байхаас үл хамааран канадчууд найрсгаар угтан авах болно. Олонүндэстэн гэдэг бидний давуу тал. Канадад тавтай морил” гэж жиргэсэн байжээ. Канадын 2011 онд явуулсан олон нийтийн судалгааны дүнгээс үзэхэд, таван канад хүн тутмын нэг нь гадаад хүн байдаг ажээ. Түүнчлэн, 2015 оны арваннэгдүгээр сараас 2017 оны нэгдүгээр сарын эхэн хүртэл тус улс 39 мянга гаруй Сирийн дүрвэгчийг хүлээн авсан байна. Тэгвэл Д.Трампын шийдвэрт Иран ч мөн хариг барьжээ. Тодруулбал, Ираны Засгийн газар америк иргэдийг хилээр нэвтрэхийг хориглож буйгаад

хэргийн яам “Хэдийгээр АНУ-ын засаг захиргааны дайсангаас бодлого, Америкийн жирийн иргэдийн үзэл бодол ялгаатайг мэдэж байгаа ч Иран улс өөрийн иргэдийн эсрэг авсан цагаачлалын хоригийг буулгах хүртэл Америкийн иргэдийг хилээрээ нэвтрүүлэхгүй болж байна” гэжээ. “Мусульман шашинтнууд, түүний дотор Ираны иргэдийг АНУ-д зорчих боломжгүй болгосон нь экстремистүүдэд том бэлэг барьж байгаатай ижил” хэмээн тус мэдэгдэлд өгүүлсэн байна. Мексикийн хил дагуу хана босгох шийдвэрээ Трамп танилцуулсны дараа Ираны ерөнхийлөгч Хасан Рухани “Өнөөдөр бол үндэстэн хооронд хана хэрэм босгодог цаг үе биш. Тэд Берлиний хана олон жилийн өмнө нурсныг мартсан бололтой” хэмээн шүүмжилж байсан юм.

ЭНЭТХЭГИЙН БҮГД НАЙРАМДАХ УЛС ТУНХАГЛАСНЫ 68 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛАВ

ЭНЭТХЭГИЙН ГАРААНЫ БИЗНЕСҮҮД: ЗӨВ ЦАГ ҮЕ ДЭХ ЗӨВ САНАА

ВИКАС ХАННА

Энэтхэгийн засгийн нэг чухал санаачилга бол шинэ бизнес эхлэх гэж буй энтерпренерүүдийн бизнесээ өргөжүүлэх болон ирээдүйд өсөн бэхжихэд нь туслахын хамт инкубаторт тухайн гарааны бизнесийг бойжуулагч, хөрөнгө оруулагчдад боломж олгодог явдал юм.

Ажилд орохоор хүсэгчдийн байнга өсч нэмэгдэж байгаа тоог ажлын байрны өсөлт хангаж чадахгүй болсон цагт Ерөнхий сайд Нарендра Модийн “Энэтхэгийн гарааны бизнесүүд” төсөл өндөр ач холбогдолтой юм. Хэдийгээр Энэтхэг улс дэлхий дээр эдийн засгийн өсөлтөөрөө тэргүүлж байгаа хэдий ч ажилгүйдлийн тоо өндөр байгаа нь Энэтхэгийн Засгийн газрын санааг зовоож байна. Ази-Номхон далайн Хүний Хөгжлийн хамгийн сүүлд гарсан илтгэлд Энэтхэг улс нь дараачийн 35 жилд өсч байгаа хүн амаа ажлын байраар хангахад ихээхэн хүндрэлтэй учирна хэмээн дурьджээ. Уг илтгэлд 1991 оноос 2013 онд “хөдөлмөрийн нас”-ны хүн амын тоо 300 саяар өссөн боловч эдийн засаг нь дөнгөж 140 саяаг нь шингээжээ. Энэ үүднээс, Засгийн газрын нэртэй нхэр төслүүд – “Энэтхэгт хийв” ба “Энэтхэгийн Гарааны бизнесүүд” дээрх асуудалд жинхэнэ харилт болох арга хэмжээнүүд гэж бодогдоно.

Дэлхийн уналтын Хятад дахь дам нөлөөнөөс хамаарч үйлдвэрлэлийн сектор уналтад орж байгаа үед ажлын байр бий болгох нэн яаралтай шаардлага гарч ирлээ. Ирж буй хэдэн арван жилд 100 сая ажлын байр бий болгохын тулд ДНБ дэх үйлдвэрлэлийн оролцоог 25 хувь хүртэл өсгөх шаардлагатай болохыг үндэсний үйлдвэрлэлийн бодлого илтгэн харуулж байна. Тиймээс, “Энэтхэгт хийв” санаачилгатай хамт шинэ гарааны бизнесүүд нь ирж буй он жилүүд дэх ажлын



The Government of India's flagship initiative is helping entrepreneurs in their expansion and future growth while also providing opportunities to incubators and investors.

байраар хангах үйлдвэрүүд байх юм. Өнөөдөр Энэтхэг нь АНУ, Британийн дараа гуравдагч хамгийн олон гарааны бизнестэй орон болж байна. Зөвхөн софтверийн чиглэлээр гарааны бизнесүүд 2017 онд 800,000 ажлын байр бий болгоно гэж УСХ таамаглажээ. Инженерийн үр чадвар хямд өртөгтэй оронд ажлын байр бий болгох хөрөнгө оруулалтыг хийх сонирхол нэлээд олон компаниудад байна. Энэ оны эхээр Энэтхэгийн Засгийн газраас компаниудад болон хөрөнгө оруулагчдад үзүүлэхээр санал болгосон татварын хөнгөлөлтийн санаачилга нь шинэ гарааны бизнесүүдийг дэмжихэд катализатор болно хэмээн үзэж байна. Засгийн газраас патентын саналыг бага үнэтэй, хурдан түргэн боловсруулахаа зарласан ба патентын үнийн 80 хүртэлх хувийг буцаан олгох, эхэлж буй гарааны бизнест 10,000 крорейн тусгай санхүүжилт олгохоо зарласан. Татвар болон заавал хэрэгжүүлэх дүрэм журмын хяналт шалгалтаас гурав хүртэлх хилээр чөлөөлөхөөр болж байгаа нь энэ секторын компаниудад үр ашигтай ажиллахад нь чухал ач холбогдолтой хэмээн мэргэжилтнүүд үзэж байна. Интернет хэрэглэгчдийн тоо их хурдтай өсч байгаа энэ үед Энэтхэг нь дэлхий дээрх гарааны бизнесүүдийн хамгийн хурдтай өсч байгаа халуун цэгүүдтэй

орны нэг хэмээн тооцогдож байна. Тус орны мобил интернет хэрэглэгчид 2013 онд 15.1 хувь байсан бол 2016 онд 34.18 хувь болж хүчтэй өсчээ. 2016 онд Энэтхэг дэх Интернет хэрэглэгчдийн 43.8 хувь нь бараа бүтээгдэхүүнээ он-лайн худалдаж авсан байна. Харин 2019 онд энэ тоо 64.4 хувь болж өсөх тооцоо гарчээ. Энэтхэг нь дижитал хувьсгалын хоёр дахь үеийн гараан дээр байна. Шинэ эдийн засагтай нүүр тулах эрүүлийг хамгаалах, боловсрол, эхуудалдаа, зочид буудал, хөдөө аж ахуй, хөдөө орон нутаг зэрэг байгууллагуудад энэ шинэ ажлын байр бий болгохтой давхцана. Дижитал худалдан авагч хүчтэй өсч байгаад урамшин саяхны хэдхэн жилд Энэтхэг дэх хөрөнгө оруулалтандаа зориулсан олон тэрбум долларыг хэд хэдэн бизнесийн капитал санхүүжилтийн сангуудад төвлөрүүлжээ. Японы Softbank ба Нью-Йоркт төвтэй хуваан эзэмшдэг албан оффисын байр олгодог WeWork зэрэг хэд хэдэн компаниуд өөрсдийн Энэтхэг дэх төлөвлөгөөгөө нийтэд мэдэгджээ. Америкийн банк Merrill Lynch Энэтхэгийн эхуудалдаа өнгөрсөн жилийн \$11 тэрбумаас 2025 он гэхэд \$220 тэрбум болж үсрэнгүй өснө гэж үзсэн байна. Программчлалаас гадна ядуучуудад зориулсан эрүүлийн хамгаалахын программ, байрт

зориулсан үнэ багатай нарны хавтан зэрэг салбарын гарааны бизнесүүдэд хөрөнгө оруулах ихээхэн сонирхол байна. Энэтхэг нь нийгмийн үр нөлөөний салбар дахь гарааны бизнесүүдэд хөрөнгө оруулах нүсэр том зах зээлийг санал болгож байна. Энэтхэгийн хөдөөд олон сая хүмүүс одоо болтол цэвэр, ундны усгүй, боловсон бие засах газаргүй, цахилгаангүй байна.

Хөдөөний хүн ам ердийн хэмжээнд жилд 8-10 хувь өсч байгаа ба 2017 онд \$100 тэрбум нэмж зарцуулахаар тооцоо гарч байна. Харин Засгийн газар баяртай мэдээтэй байгаа ба Ерөнхий сайд Мод хөдөөний тосгон бүрийг 2018 он гэхэд нарны энергээр хангах ажлыг хэрэгжүүлэхийн тулд олон тэрбум ам.долларын санхүүжилт хийхээр болсон. Модийн Засгийн газар нарны энергийн чадавхийг 2022 он гэхэд тав дахин өсгөж 100,000 MW-д хүргэх ба ингэснээр өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэгцээг хангаж, ажлын шинэ байрууд бий болгох юм.

Шинэ гарааны бизнес эрхлэгчид буюу энтерпренерүүдийн бараг 70 хувь нь 35 наснаас дооших насны иргэд байгаа учраас Энэтхэг бол дэлхий дэх хамгийн залуу гарааны бизнес эрхэлдэг улс болж байна. Ойролцоогоор гурваас дөрвөн мэдээллийн технологийн гарааны бизнесүүд Энэтхэгт өдөр бүр үүсэн бий болж байна. Өнгөрсөн жилүүдэд, ажил эрэгчээс ажил олгогч болох гэсэн тактикийн шинэчлэлт залуучуудын оюун ухаанд бүрэлдэн бий болж байна. Тийм ч учраас, “Энэтхэгийн Гарааны бизнес” нь энэ орны залуусийн мөрөөлдөө биелүүлэхэд жигүүр болсон гайхамшигтай талбар болж байна.

Энэ нийтлэл нь 2016 оны 11, 12 дугаар сарын “ИНДИА ПЕРСПЕКТИВИС” хэвлэгдсэн.

Англи хэлнээс орчуулсан Д-р Я.НЯМДОРЖ



Шинэ Делид болсон “Энэтхэгийн Гарааны бизнес”-н нээлт дээр Ерөнхий сайд нээж Моды үе хэлж байгаа нь



Ерөнхий сайд Гарааны бизнесийн төлөөлөгчид, компаниуд, болон хөрөнгө оруулагчидтай ярилцаж байгаа нь



Ерөнхий сайд Моды, Холбооны Сангийн сайд, ноён Арун Жаитлеи, Худалдаа үйлдвэрийн Төрийн сайд, хатагтай Нирлала Ситаралан нарын халт “Энэтхэгийн Гарааны бизнес” төслийн нээлт дээр

ЦАГ ҮЕ

ТОМИЛОЛТ



ДАРХАНЧУУД ЭРЧИМ ХҮЧ, УСАН ХАНГАМЖИЙН 2020 ОН ХҮРТЭЛХ ХӨГЖЛӨӨ ТОДОРХОЙЛОВ



Н.БАТЗАЯА

Монгол орны аж үйлдвэрийн томоохон төв гэгддэг Дархан-Уул аймаг эдүгээ Монголын загвар хот болон хөгжиж буй. Тэртээ 1961 онд Давхрын төмөр замын өртөө, барилгын түүхий эдийн ордуудыг түшиглэн баригдаж байсан Дархан-Уул аймаг зам харилцаа, дэдбүтэц, эдийн засаг, гадаад харилцаа хөгжсөн томоохон аймгуудын нэг болсон. Тэгвэл Дархан-Уул аймаг өнгөрсөн баасан гарагт эрчим хүч, усан хангамжийн системийн өнөөгийн байдал болон хэтийн зорилтынхоо талаар хэлэлцэв. Энэхүү зөвлөгөөнийг Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн алба хамтран зохион байгуулсан бөгөөд эрчим хүчний салбарын удирдлага, инженерүүд оролцсон юм. Зөвлөгөөнийг нээж, тус аймгийн Засаг дарга С.Насанбат “Өнөөдөр бид “Дархан хотын эрчим хүч, усан хангамжийн системийн өнөөгийн байдал үнэлэлт өгөн, хөгжлийн чиг хандлага”-ыг тодорхойлж, 2020 он хүртэлх зорилт тавьж, өмнөх зөвлөгөөний адил тодорхой асуудлуудыг хөндөн, хэрэгжүүлэх арга зам, боломжийг хэлэлцэж зөв гарцыг олсноор бодитой хэрэгжих төлөвлөгөөтэй, хариуцах эзэнтэй арга хэмжээ болгон баримтжуулсан баримт бичгээ гаргах болно. Дархан хот үйлдвэрлэл дэд бүтэц хөгжсөн, хүн ам олноор суурьшсан, аж үйлдвэрийн томоохон цогцолбор болгон хөгжүүлэх бодит боломжтой бүс нутгийн төв гэдэгт үе үеийн төр засгийн удирдлагууд анхаарлаа хандуулж, “Төвийн бүсийн тулгуур төв”, “Дархан хөгжлийн загвар хот” болгох Засгийн газрын тогтоол, шийдвэр гаргаж хэрэгжүүлж байсан нь хотын цаашдын хөгжилтэй цаашдын хөгжилтэй онцгой ач холбогдол өгч, дарханчууд бидэнд эрүүл тэглэл амьдралын орчин бүрдэхэд онцгой дэмжлэг болсоор ирсэн” гэв. Энэ удаагийн зөвлөгөөнд нийт 12 илтгэгч эрчим хүч, усан хангамжийн салбарын тулгамдаж байгаа асуудлыг хөндөн цаашд хийж, хэрэгжүүлэх шинэ санааг дэвшүүлсэн юм.

Зөвлөгөөний үеэр Дархан-Уул аймгийн Захирагчийн албаны дарга Э.Равжаадэлгэрэх “Дархан-Уул аймгийн эрчим хүч, усан хангамжийн салбарт тодорхой хэмжээгээр хөрөнгө оруулалт хийгдэж байна. Ялангуяа инженерийн шугам, сүлжээний байгууллагад улсын хэмжээнд анхдагч гэсэн шинэ шийдэл бүхий томоохон хөрөнгө оруулалт хийгддэг. Тухайлбал, манай аймагт Монголын анхны нарны цахилгаан станц ашиглалтад орсон. Мөн хаягдал хогийг ангилан боловсруулж, эрчим хүч үйлдвэрлэдэг үйлдвэрийн барилгын ажил эхэллээ. Түүнчлэн төв цэвэрлэх байгууламж маань бүрэн шинэчлэгдэж гэж байгаа. Энэ мэтчилэн олон ажил хийгдэж байна. Гэхдээ бидэнд зарим зүйл дээр тулгарч байгаа асуудлууд анхаарал хандуулж ажиллах, цаашдын зорилго, зорилт, төлөвлөгөөгөө салбарынхаа хэмжээнд ярилцах шаардлага гарсан” гэв. Ийнхүү ярилцсаны дараа бид Дархан-Уул аймгийн эрчим хүч, усан хангамжийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцсан юм.

ШИНЭ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ 2019 ОНД АШИГЛАЛТАД ОРНО

“Дархан-Ус суваг” хувьцаат компани нь 1500 үйлдвэр аж ахуйн газар, 12 мянга гаруй айл, өрхийг цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах гэрээ байгуулан ажиллаж байгаа аж. Энэ хүрээнд гэр хорооллын 28 мянган хүн амд нийт 40 ус түүгээх цэгээр дамжуулан цэвэр ус түүгээх үйлчилж байгаа гэнэ. Тус компанид өнгөрсөн хугацаанд бүтээн байгуулалтын томоохон ажлууд хийгдсэн талаар компанийн захирал П.Ариундалай онцолж байв. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газар, Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 2011 онд 14.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, “Дархан хотын усан хангамжийн байгууламжийг сайжруулах” төслийг амжилттай хэрэгжүүлжээ. Мөн 2015 онд гэхэд АНУ-ын Аляска мужийн “Fairbank”-ийн

цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа, лаг боловсруулах технологийн туршлага судлах судалгааны төсөлд хамтран ажилласан байна. Харин 2017 онд хэд хэдэн томоохон ажлыг төлөвлөжээ. Түүний нэг нь Азийн хөгжлийн банкны 20.7 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар цэвэрлэх байгууламжийг тоног, төхөөрөмжийн хамт бүрэн шинэчлэхээр болсон аж. Энэхүү төсөл 2019 онд бүрэн хэрэгжиж дуусах юм байна. Мөн айл өрхийн тоолуурыг ухаалаг системд шилжүүлэн зоорин давхарт нэгтгэхээр болсон гэнэ. Ингэснээр айл болгоны хаалгыг тогшиж, тоолуурын заалтыг нэг бүрчлэн бичиж тэмдэглэдэг хуучны аргачлалаас салах юм байна. Бүтээн байгуулалтын ажлын хажуугаар шийдэх тодорхой ажлууд байгаа гэдгийг ч тус компанийн захирал П.Ариундалай хэлж байлаа. Тэрбээр “Бид цэвэр усаа 1680 төгрөгөөр олборлож, иргэдэд 993 төгрөгөөр зардаг. Харин бохир ус татан зайлуулахдаа 1343 төгрөгөөр олборлож, 1133 төгрөгөөр татан зайлуулдаг.

Үүнээс болж манай компани цэвэр ус түүгээхээс 687 төгрөг, бохир ус татан зайлуулалтаас 215 төгрөгийн алдагдал хүлээдэг. Өөрөөр хэлбэл, манай компани алдагдалтай ажиллаж байгаа юм. Улс орны өнөөгийн нөхцөл байдал, иргэдийн амьдралын төвшингөөс шалтгаалаад усны тарифаа хоёр жил нэмээгүй. Тиймээс энэ жил бага зэрэг нэмэх асуудал яригдаж байгаа” гэв.

ДДС-Д 35 МГВ-ЫН ӨРГӨТГӨЛ ХИЙГДЭЖ БАЙНА

Манай сурвалжлах хэсгийн очсон дараагийн газар 52 жилийн түүхтэй “Дархан дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компани байв. Дархан хотын эрчим хүчний цорын ганц эх үүсвэр гэгддэг станцын үйл ажиллагаатай тус компанийн гүйцэтгэх захирал Н.Чимэддорж танилцуулсан. Тэрбээр “Манай дулааны станц он цагийн хувьд нэлээд хуучирсан. Хүнээр бодоход 52 нас гэдэг нэлээд зүйл хийсэн нас шүү дээ. Олон жилийн үйл ажиллагаанаас шалтгаалаад техник, технологийн хувьд ч хуучирч байна. 1987 онд ЗХУ-ын хөрөнгө оруулалтаар гурван том зуух суурилуулсан. Түүнээс хойш тэрбум төгрөгөөс илүү хөрөнгө оруулалтын ажил хийгдээгүй. Манай станцын тоног төхөөрөмжийн үйлдвэрлэсэн компаниас үндсэн үйлдвэрлэлдээ анхаарал тавихгүй бол хэзээ ч зогсоход бэлэн болсон байна. Тиймээс аюулгүй ажиллагаа талдаа онцгой анхаарч ажиллах хэрэгтэй гэдэг зөвлөмжийг өгсөн. Энэ зөвлөмжийн дагуу бид 2004 оноос эхлэн тасралтгүй үйлдвэрийн цаашдын үйл ажиллагааны талаар

ярилцаж, техникийн зөвлөлөөс удаа дараа зөвлөмж гаргасан. Үүний үр дүнд 2006 оноос эхлэн станцыг өргөтгөх тухай асуудал ноцтой яригдаж эхэлсэн. Ингээд 2011 онд ХБНГУ-ын 23 сая еврогийн хөрөнгө оруулалтаар 35 мГв-ын өргөтгөлийн ажлыг эхлүүллээ. Одоогийн байдлаар төслийн үйл ажиллагаа удаашралтай байгаа хэдий ч шаардлагатай тоног, төхөөрөмжүүд ирсэн байгаа” гэсэн юм. Энэхүү станцын өргөтгөл 2018 оны нэгдүгээр улиралд ашиглалтад орохоор төлөвлөсөн байна. Мөн Монгол Улсад ганцхан Дархан хотын дулаан хангамж нээлттэй системтэй байдаг гэнэ. Өөрөөр хэлбэл, халаалтын системээсээ шууд халуун усаа авч хэрэглэдэг хэмээн тус компанийн захирал Н.Чимэддорж тайлбарласан юм. Энэ нь 1965 оны үеийн аргачлал бөгөөд орчин үеийн стандартад нийцсэн тусдаа системийг нэвтрүүлэх шаардлага гарсан аж. Тиймээс Дархан хотын ус хангамжийг хаалттай системд шилжүүлж байгаа юм байна. Ингэснээр дулааны цахилгаан станцын өөрийн зардал буурах гэнэ. Мөн тэрбээр Дархан-Уул

...Дархан нарны цахилгаан станцын бас нэгэн нэг онцлог гэвэл уг төсөл Япон улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах төсөлд олгодог Хамтарсан кредитийн механизмд хамрагдахаар батлагджээ. Энэхүү 10МВт-ын хүчин чадалтай Нарны цахилгаан станц нь жил бүр 14.182 сая киловатт цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх тул жил бүр 14.746 тонн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах боломжийг бүрдүүлэн...

Аймагт дулааны хоёр дахь эх үүсвэрийг барих шаардлага тулгарсан гэдгийг онцлов.

ЖИЛД 500 САЯ кВт ЭРЧИМ ХҮЧ ДАМЖУУЛДАГ

Монгол улсын нутаг дэвсгэрийн 80 гаруй хувийг цахилгаан эрчим хүчээр ханган ажилладаг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн төвийн бүсийн таван салбарын нэг нь Дархан-Уул аймагт байрлан ажилладаг. Үндэсний хэмжээний томоохон компаниудын нэг болох тус компани жилд 500 сая кВт эрчим хүчийг үйлдвэрлэдэг. Ингэхдээ 9000 гаруй аж ахуйн нэгж, байгууллага, 50 гаруй мянган өрхийг цахилгаан, эрчим хүчээр ханган ажилладаг байна. Тэгвэл манай сурвалжлах хэсэг тус компанийн Дархан-Уул аймаг дахь салбарын үйл ажиллагаатай танилцав. Энэ үеэр Дархан-Уул аймаг дахь салбарын дарга Ж.Мөнхжаргал “Цахилгаан эрчим хүч гэдэг өөрөө онцлог бүтээгдэхүүн.

Үүссэн цагаасаа эхлэн 24 цагийн турш буюу тасралтгүй үйл ажиллагаа явуулж байдаг. Биднийг унтаж, амарч байхад ч цахилгаан үйлдвэрлэгддэг, дамжуулан түгээгдэж байдаг. Үүнээс гадна цахилгаан эрчим хүчний бүтээгдэхүүнийг хадгалж болдоггүй. Үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлт, хэрэглээ нэг секундний хугацаанд явагддаг. Хоорондоо нягт холбоотой гэсэн үг. Тиймээс бид зохион байгуулалтын өндөр төвшинд хагас цэрэгжилтийн байдлаар ажилладаг” гэв. Мөн тэрбээр тус салбар ОХУ-ын эрчим хүчний системтэй Монголын эрчим хүчний системийг холбодог хамгийн том зангилаа станц болдог. Манай улсын эрчим хүчний систем дангаараа оршин тогтнох хэцүү учраас ОХУ-ын эрчим хүчний системтэй холбогддог хэмээн тайлбарлав. Ингэснээр эрчим хүчний найдвартай ажиллагааг дээшлүүлдэг аж. Түүнчлэн дамжуулж буй эрчим хүчнийхээ 80 гаруй хувийг Дархан, Сэлэнгийн цахилгаан сүлжээ буюу тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд нийлүүлдэг байна. Үлдсэн хувийг бусад тусгай зөвшөөрөл эзэмшигч рүү шилжүүлдэг ажээ.

МОНГОЛЫН АНХНЫ НАРНЫ ЦАХИЛГААН СТАНЦ АМЖИЛТГАЙ АЖИЛЛАЖ ЭХЛЭВ

Монгол Улсын эрчим хүчний салбарт өнгөрсөн нэгдүгээр сард нэгэн дэвшилд хүрсэн томоохон үйл явдал болсон нь Дархан-Уул аймаг дахь нарны цахилгаан станцын нээлт байв. Түүхийн хуудсыг дахин сөхөвлөн өнгөрсөн оны долдугаар сарын 19-нд Дархан хотод төвтэй Монгол Улсын Солар Повер Интернешнл компани Япон улсын Шарп корпораци болон Шигемүтци Шожи компанитай хамтран 10МВт-ын хүчин чадалтай Нарны цахилгаан станц байгуулах гэрээнд гарын үсэг зурж, өнгөрсөн нэгдүгээр сард ашиглалтад орсон. Тус станц жилд 14.1 сая кВт/цаг эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай гэнэ. Энэхүү цахилгаан станц ашиглалтад орсноор 20 мянган айл өрхийг сэргээгдэх эрчим хүчээр хангах боломж бүрдэж улмаар жилд 14.746 тонн хүлэмжийн хий ялгаруулахаас сэргийлэх ач холбогдолтой аж. Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутаг дэвсгэрт байрлах тус станцын гадаа 34 мянган модулийг байрлуулжээ. Энэхүү модуль нь нарны тусламжтайгаар эрчим хүчийг үйлдвэрлэх бөгөөд 25 жилийн баталгаатай. Гэхдээ нарны цахилгаан станц 140-150 жилийн настай байдаг гэдгийг тус компанийн захирал Б.Мандалбаяр онцолсон. Дархан нарны цахилгаан станцын бас нэгэн нэг онцлог гэвэл уг төсөл Япон улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах төсөлд олгодог Хамтарсан кредитийн механизмд хамрагдахаар батлагджээ. Энэхүү 10МВт-ын хүчин чадалтай Нарны цахилгаан станц нь жил бүр 14.182 сая киловатт цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх тул жил бүр 14.746 тонн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах боломжийг бүрдүүлнэ. Энэ нь нүүрсээр ажилладаг уламжлалт цахилгаан станцыг голлон ашиглаж байгаа манай орны хувьд Шарп компанийн нарны станц байгуулах өндөр технологийг нутагшуулах замаар Монгол Улсад байгаль орчинд ээлтэй сэргээгдэх эрчим хүчний технологиор нэвтрүүлэхэд чухал хувь нэмэр оруулах юм байна. Дархан нарны цахилгаан станц

ашиглалтад орсон цагаасаа 918 мянган кВт цахилгааныг үйлдвэрлээд байгаа ажээ.

ДДС ТӨХК ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ БҮРЭН ХАНГАЖЭЭ

Дарханы дулааны сүлжээ төрийн өмчит хувьцаат компани нь Дархан-Уул аймгийн 1200 гаруй орон сууцны оршин суугч, 1500 гаруй аж ахуйн нэгжүүдэд дулааны эрчим хүчээр ханган ажилладаг байна. Тус компани Дарханы дулааны цахилгаан станцаас жилд 500 мянга орчим кВт дулааныг худалдан авч хэрэглэгчиддээ түгээдэг гэнэ. Мөн энэ жилийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг бүрэн хангаж, хэрэглэгчдийнхээ ая тухтай байдлыг ханган ажиллаж байгаа аж. Энэ талаар тус компанийн гүйцэтгэх захирал Д.Гантуул “Манай компани 2016-2017 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг 100 хувь биелүүлсэн. Бага зэргийн гэмтэл гарсан хэдий ч тухай бүрт нь найдвартай арга хэмжээ авч ажилласан. Ер нь ойрын жилд дулааны хэрэглээ тав орчим хувиар нэмэгдэх судалгаа бий. дулааны хэрэглээ бага багаар нэмэгдэж байна гэсэн үг. 2013 онд нэлээд өсөлттэй байсан. Түүнээс хойш улс орны эдийн засгийн байдал, орон сууцны барилгын борлуулалт зогсонг байдалд шилжсэнтэй холбогдуулан хэрэглээ багасч байсан юм. Одоо эргээд нэмэгдэх шинж ажиглагдаж байна” гэсэн юм. Мөн дархан дулааны сүлжээ төрийн өмчит хувьцаат компани энэ жил төв шугам сүлжээгээ засварлах ажлыг төлөвлөсөн байна. Түүнчлэн “Дархан хотын дулаан хангамжийг сайжруулах” төсөл хэрэгжих гэнэ. Энэхүү төсөл нь 20 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх бөгөөд 2020 он хүртэл тодорхой үе шаттайгаар хэрэгжих юм байна. Уг төсөл нь хэрэгжсэнээр Дархан-Уул аймгийн дулаан хангамж 100 хувь хаалттай системд шилжих бөгөөд хэрэглэгчдэд очих хэрэгцээний халуун усны чанар дээшлэх давуу талтай аж.

2016 ОНД 7.2 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙВ

Монгол Улсын гал голомт болсон эрчим хүчний салбарт томоохон бүтээн байгуулалтын ажил хийгдэж байгаа нь сурвалжлага хийх явцад харагдаж байна. Тухайлбал, “Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” хувьцаат компани 2016 онд хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажилд 7.2 тэрбум төгрөгийг зарцуулжээ. Энэ тухай тус компанийн дэд захирал Б.Батжаргал “ДСЦТС компани Монголын эрчим хүчний салбарт анх удаа цахилгаан эрчим, хүчний хяналт, удирдлага, арилжааны автоматжуулалтын системийг нэвтрүүлээ. Энэхүү ажлын хүрээнд ухаалаг тоолуурын систем, диспетчерийн хяналтын систем болон хяналтын камерын систем зэргийг цогцоор нь шийдсэн. Мөн өнгөрсөн онд Дархан-Уул аймгийн Дархан, Шарын гол, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Цагаан нуур сумдад нийт 17 мянга гаруй ухаалаг тоолуур суурилуулсан” гэв. Мөн тус компанийн өөрсдийн хөрөнгөөр 35/10(6) кВт-ын хоёр дэд станц шинээр барьж, нэг дэд станцыг шинэчилжээ. Түүнчлэн 35 кВт-ын 34 км цахилгаан дамжуулах агаарын шугамыг дэвшилтэт технологигор барьж байгуулан ажилласан байна.

STRESS

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Нийслэлчүүд утааны эсрэг нэгдлээ

Б.СУМБЬЯ

2017 оны нэгдүгээр сарын 28. Өвлийн жавар ид тачигнаж, өдөртөө -22 хэм хүрч хүйтэрч, жижүүн салхи салхилож байсан ч ээж, аавууд утааны эсрэг нэгдэн “Боож үхлээ” жагсаалд оролцлоо. Гартаа хар өнгийн шаар барьсан багачууд, амандаа маск зүүсэн эцэг, эхчүүд, “Биднийг авраач” хэмээх бичиг барьсан залуус гээд нас насны хүмүүс тус жагсаалд нэгдэхээр хүрэлцэн ирсэн байв. Тэд “Монголд эх хүн байх хэцүү байна. Ээжүүд хэвийдээ тээж буй үрийн маань зүрх цохилох болов уу гэж айдаг боллоо. Бидний үрс утаанаас болж хордож байгаад боож үхлээ. Утааны эсрэг зоригтой алхам хийгээч. Утааны эсрэг нэрээр шахааны бизнес хийхгүй байхыг шаардаж байна” хэмээн орилцгоож байсан юм. Жагсаалд оролцогсод

“Үр удмаа утаанаас аварья”, “Ээждээ тэврүүлээр байна”, “Биднийг авраач” хэмээх зурагт хуудастай самбар байршуулж, барьсан байсан байлаа. Утааны эсрэг “Боож үхлээ” жагсаалыг зохион байгуулагч Ц.Пүрэвхүү “Одоогоор “Боож үхлээ” жагсаалд 5000 гаруй эцэг, эхчүүд ирсэн. Бид 10 мянган өргөдлийн маягт бөглүүлэхээр тараасан байгаа. Хэрэв энэ өргөдөлд 10 мянган хүн гарын үсэг зурсан бол цуглуулах үед тоо нь тодорхой болно. Сая Монголын үйлдвэрчний соёлын төв ордноос утааны эсрэг жагсаалын цуваа төв талбайд хүрэлцэн ирлээ. Энэ бол баярын жагсаал, концерт биш. Бид хотын утааг эсэргүүцэж, боох үхэх шахсандаа жагсаж байна” гэсэн юм. Идэр есийн хүйтэнд ирээдүй болсон хүүхдийнхээ эрүүл мэндийн төлөө жагсаж буй ээж, аавуудтай нэгдэхээр урлагийнхан хүрэлцэн ирж, ая дуугаа

өргөсөн бол гэрэл зурагчид мөн утааны эсрэг нэгдэн үзэсгэлэн гаргаж, зургаараа өөрсдийн үзэл бодлоо илэрхийллээ. Улмаар жагсаалын төгсгөлд Засгийн газрын ордонг нар зөв тойрч, утааны хор уршгийг харуулах үүднээс хар өнгийн шаар буюу “хар шаардлага”-ыг Төрийн ордны хашаанд өлгөлөө. Энэхүү шаардлагын эхний харигт 2017 оны хоёрдугаар сарын 15-ны дотор багтаан “Утааны эсрэг ээж, аавууд” төрийн бус байгууллагад бичгээр, мөн нийт иргэдэд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан танилцуулахыг шаардаж байгаа аж.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр -14
Шөнө -25

Нөгөөдөр
Өдөр -12
Шөнө -22

Өдрийн зурхай

ӨВЛИЙН АДАГ ЦАГААГЧИН ҮХЭР САР НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ УЛААГЧИН МОГОЙ ӨДӨР

Наран ургах шингэх: 08.23-17.49
Үс засуулбал: Эд мал баялаг төгөлдөр болно



Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Баяр баясаалангийн хурил үйлдэх, шинэ гэр барих, хувцас өтсөх, чимлэг зүүх, бүжиг наадам үүсгэх, эм засал хийлгэх, авшиг авах, бэрийн үйл, дайсныг дарахад болон хуран чуулах, үс угаахад сайн. Зүүн нүд татвал хувцас олох, баруун нүд татвал тэмцэл болох, баруун чих хангинавал сайн, зүүн нь хангинавал өчүүхэн нэгнийг үзэх, тагнай загатнах, бие татвал үзэсгэлэн болох, хөлийн шөрлөс татвал үг, асуулт болох болой. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, торь, хонь, нохой, гахай болой.



Бидэнд тохиолдсон

Л. Бархас

Хоч нэр хэцүү шүү. Би таван жилийн өмнө дадлага хийхээр 14 хоног хөдөө явсан юм. Нэг юм сүлжээтэй газар олоод л шууд эмээ рүүгээ залгав аа. Би “Байна уу эмээ. Байна уу Бархас байна” гэтэл эмээ “Хэн гэнэ ээ” гэлээ. “Бархас байна аа, Бархас” гэтэл “Хэн гэсэн бэ хүүхээ” гэдэг юм. “За за Донхоно байна аа” гэсэн чинь “Аан миний хүү сайн явж байна уу” гэж авдаг юм даа. Ха ха ха. Ядаж байхад хажууд ангийнхан байсныг ч хэлэх үү, бүгд л одоо Донконо Донконо гэж шоолдог болсон доо.

ДУУЛГАХ СОНИН



ХӨЛ ХҮНД НАТАЛИ СЭТГЭҮҮЛИЙН НҮҮРИЙГ ЧИМЛЭЭ

Б.ДАВАА

Чадварлаг жүжиглэлт, сэтгэл татам төрхөөрөө дэлхийн кино сонирхогчдыг байлдандагуулдаг эмэгтэй боляхаргагүй Холливудын үзэсгэлэнт гүнж Натали Портман. Кино урлагийн ертөнцөд 13 настайгаасаа анх хөл тавьсан тэрбээр “Хар хун” киноныхоо дүрээр Оскарын шагнал хүртэж явсан бөгөөд тэр дүрээр нь ч манай үзэгчид таних биз ээ. Тэгвэл жүжигчин бүсгүй эдүгээ хоёр дахь хүүхдээ тээж байгаа юм. Өнгөрсөн оны есдүгээр сард жирэмсэн болсноо зарласан тэрбээр уран бүтээлийнхээ ажлаас түр завсарлага авсан байдаг. Харин энэ удаа хөл хүнд зургаараа загварын “Ванити фэйр” сэтгүүлийн нүүрийг чимж, шүтэн бишрэгчидтэйгээ “мэндчиллээ”. Эдүгээ 35 настай Натали таван настай Алеф гэх хүүтэй. Түүний нохор нь “Хар хун” кинонд хамтран ажилласан балетын бүжигчин Бенжамин Миллипид юм.

Мадонна ХҮҮХЭД ӨРГӨЖ АВАХ ГЭНЭ

Дөрвөн хүүхдийн эх дуучин Мадонна АНУ-ын ерөнхийлөгч Д.Трампыг эсэргүүцсэн “эмэгтэйчүүдийн жагсаал”-д идэвхитэй оролцсон нэгэн. Д.Трамптай харилцаа тааруухан оддын нэг тэрбээр Малави улсаас дөрвөн настай ихэр эгч дүүсийг өргөж авахаар хүсэлт гаргажээ. Энэ тухай мэдээллийг дуучин эмэгтэй тун ихээр нууцалж байгаа бөгөөд шүүхэд хүүхэд үрчилж авах өргөдөл өгөөд гарч ирсэн хойноо ч энэ бол худал мэдээлэл хэмээн няцааж байжээ. Тэрбээр Малави улсад

хүүхдийн эмнэлгийн явц болон “Raising Malawi” сангийн үйл ажиллагааны хүрээнд ирсэн гэж тайлбарлаж байлаа. Албаны хүний хэлж буйгаар, Мадоннагийн хүүхэд үрчилж авах хүсэлт, холбогдох материалуудыг дээд шүүх хүлээн авсан бөгөөд танилцах шатанд явж байгаа гэнэ. Хэрэв түүний хүсэлтийг хүлээн зөвшөөрөх аваас Мадонна Эстер, Стелла хэмээх ихэр охидтой болох юм. Тэрбээр тус улсаас Дэвид хүү болон Мерси Жеймс охиноо өргөж авч байжээ.

Нар мандаж, жаргаж бас дахин мандана. Эрээнтэй бараантай амьдралын эгэл бор өдрүүд дунд аав тэмцсээр, гэр бүл хань ижил, үр хүүхдүүдийнхээ төлөө зүтгэсээр л. Амьдрал амаргүй байсан ч тэр архинд ороогүй, хүсэл мөрөөдөл нь биеллэгүй ч тэр гутарч гуунаагүй, хэцүү цагт тэр гэр бүлээ орхиж яваагүй...